МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,105.832... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.09.19. Даваа. №166 (4536) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ



# А.ИШДОРЖ:

## АЙМГИЙНХАА ХӨТӨЛБӨРИЙГ ЗАСГИЙН ГАЗРЫНХТАЙ УЯЛДУУЛААД ЯВНА ГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ БАЙНА

Дэлгэрэнгүй ярилцлагыг IV нүүрнээс

УЛС ТӨР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ХАГАС ЗУУН ЖИЛИЙН ДАРАА КУБА УЛСАД АЙЛЧИЛЛАА

II нүүрт

УЛС ТӨР

УБТЗ Ю.ЦЭДЭНБАЛ АГСНЫ ВАГОНЫГ МӨНХИЙН ЗОГСООЛД ЗАЛАВ

V нүүрт

## ДАВХАР БАЙШИНТАЙ УЛААН ХИВСТЭЙ НЬ МАН, БАЙШИНГИЙН БУЛАНД ХОРГОДОЖ БАЙГАА АН

Х.НОРЖИН

Ирэх аравдугаар сард орон нутгийн ИТХ-ын ээлжит сонгууль болно. Улс төрийн өнөөгийн нөхцөлд орон нутаг бол улс төрийн аль ч хүчний хувьд алдаж болохгүй зүйл. УИХ-ын ээлжит сонгуульд ялагдсан АН-ын тухайд орон нутагт “хөлтэй” болохын тулд эцсийн хүчээ шавхах бодлого барьж ажиллахыг уриалсан бол өдрөөс өдөрт нэр нь унаж байгаа МАН ч ялгаагүй орон нутгийг сөрөг хүчинд алдах учиргүйгаймаг, нийслэл, сум, дүүргийн намын бүх хороо, үүрүүддээ сануулсан байна. Гагцхүү ялалтын тугны өнгө цэнхэр үү, улаан уу гэдгийг улс төрийн намуудын тактик, бүх шатанд ажиллах сонгуулийн менежерүүдийн туршлага, нэр дэвшигчдийн нэр хүнд, хэлж ярих зүйлээс ихээхэн шалтгаална. АН-ын тухайд олж харж, ашиглаж чадвал ард түмний цоожилж орхисон хаалганы оньс мултрахад ойрхон буй. Орон нутгийн ИТ-ын сонгуульд нэр дэвшсэн нөхдүүдийг нь ч харахад ихэнх нь УИХ-ын болоод НИТХ-д нэр дэвшсэн улстөрчид байна лээ. Тэд мэдлэг боловсрол, олонд танигдсан нэр нөлөө, хийсэн ажил, санаачилсан, боловсруулсан хуулийн төсөл энэ тэрээрээ МАН-аас нэр дэвшиж байгаа хэн ч танихгүй, олонд танигдаагүй залуучуудыг арчаад өнгөрч мэднэ.

Үргэлжлэл нь III нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




Дугаарын 60 мөр

## Группийн мөнгөнд “шургалсан” намчирхал

Н.ПУНЦАГБОЛД

2016 оны сонгуулийн дараа байгуулагдсан үнэмлэхүй ялагч МАН-ын Засгийн газар болж өгвөл хэмнэлт хийхийг хүссэн. Уг нь бол зөв бодлого. Бид хэмнэж болох бүхнээ хэмнэх л ёстой. Гэхдээ ард иргэд гэртээ идэж байгаа хоолныхоо ногоог цөөлж, хонины махаа ямааныхаар солих биш л дээ. Хүн гэртээ яаж хэмнэх нь өөрийн дур. Харин төрийн хэмжээнд өгч байгаа хавтгай халамж, зарж байгаа их мөнгөө л хасаж, танаж, хэмнэх ёстой юм. Түүнийгээ эрх баригчид яг нарийн ойлгож чадахгүй байсан. Зарим гишүүд нь хэмнэлт гэхээр иргэд талхаа масло түрхэлгүй идэхийг хэлэх юм шиг ойлгоод, чуулганы танхимаас ард түмнээ загнаж ч байх шиг. Энэ мэтээр өрнөсөн хэмнэлт сүүлдээ эргэлт буцалтаар л дууссан. Гэвч ам нээснийх ганц нэг үр дүн гарч байгаа бололтой. Тухайлбал, хөдөө орон нутагт хавтгайрчихаад байсан группийн мөнгийг эмх цэгцэнд нь оруулж байгаа гэнэ.

Үргэлжлэл нь II нүүрт

ТОМИЛОЛТ

## ЕРӨНХИЙ САЙД Ж.ЭРДЭНЭБАТ

### Сэлэнгэ, Дархан-Уул аймагт ажиллалаа



Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат орон нутагт хийх анхны томилолтоо төрөлх нутаг Сэлэнгэ аймгаасаа эхлүүлж, Сэлэнгийн Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар, Мандал, Баянгол сум Дархан-Уул аймгийн Дархан, Хонгор, Орхон суманд ажиллаж тариалалт, ургац хураалтын явц, ногоо хураалт, хадгалалттай танилцаж, тариаланч, ногоочид, ард иргэдтэй уулзан тэдний санал хүсэлтийг сонсч, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн талаар мэдээлэл өгч явлаа.

Мөн Мал аж ахуй, газар тариалан зэрэг хөдөө аж ахуй манай улсын түүчээлэх салбар байх учиртай. Малчид, тариаланчид, ногоочид маань үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээрээ, түүний чанараар хоёр хөрш төдийгүй дэлхийд өрсөлдөх, нийлүүлэх боломж бий.

Үргэлжлэл нь V нүүрт




“ШИНЭ ТӨГӨЛ” ЦЭЦЭРЛЭГ

ТАВТАЙ МОРИЛ

Олон Улсын стандартад нийцсэн “Шинэ төгөл” цэцэрлэг “Маршал таун” хотхонд нээгдэж, 2016-2017 оны хичээлийн шинэ жилийн элсэлтээ авч эхэллээ. “Шинэ төгөл” цэцэрлэг нь нийслэлийн хамгийн цэвэр агаартай бүсэд өөрийн зориулалтын, бие даасан байрандаа танай хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд сургахын зэрэгцээ зөв монгол иргэн болж төлөвшихөд бэлтгэнэ.

**АНГИ БҮРИЙГ КАМЕРЖУУЛСАН ТУЛ ТА ХҮҮХДЭЭ АЖИЛ БОЛОН ГЭРЭЭСЭЭ ХЯНАХ БОЛОМЖТОЙ.**



Нэг ангид хоёр багштай ба анги дүүргэлт 15-20 хүүхэдтэй. Манай цэцэрлэг нь пластик ширээ, сандал, тавилга, тоглоомоос татгалзаж хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгалийн гаралтай цэцэрлэгийн стандартыг бүрэн хангасан модон ширээ, сандал, тавилгатайгаас гадна АНУ болон Европын сэтгэхүй хөгжүүлэх, сэдэвт, тоо тооллын, бие бялдар хөгжүүлэх тоглоом мөн Японы сургалтын хэрэглэгдэхүүнтэй. Сургалтын хөтөлбөрийн хувьд сургуулийн өмнөх боловсролын ЦӨМ хөтөлбөрийг The Academy of English - ийн JOLLY KIDS 4-5 настай хүүхдэд зориулсан Англи хэлний сургалттай хослуулан хэрэгжүүлж байгаагаараа онцлог юм.

Сургалтаараа хүүхдийг амьдрах ухаан, хэл яриа, тоо тоолол, ёс заншил, урлаг соёл, байгаль болон хүрээлэн буй орчныг танин мэдэхэд сургахаас гадна хүүхдийн биеэ даах, аливаа асуудлыг өөрөө шийдэх, нийгэмших, баг хамт олноор ажиллах, бүтээлч чадварыг хөгжүүлнэ.

Түүнчлэн манай чадварлаг тогооч нарын бэлтгэсэн хоол нь зөвхөн хүүхдэд зориулсан байдаг төдийгүй байгалийн органик гаралтай, амин дэм, витаминаар баялаг, өөх тос багатай, шарж хуураагүй байдгаараа давуу талтай юм. Үүнээс гадна манай гал тогоо нь өндөр зэрэглэлийн Европын техник төхөөрөмжтэй тул хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй юм.

ТАНЫ БЯЦХАН ҮРС ЗӨВ МОНГОЛ ХҮН БОЛНО
Холбоо барих утас: 99094864

| | ХААН банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2238.00 | 2253.00 | ФУНТ | 2920.00 | 3009.00 |
| ЕВРО | 2483.00 | 2564.00 | РУБЛЬ | 33.30 | 36.10 |
| ИЕН | 21.73 | 22.28 | ЮАНЬ | 336.00 | 339.20 |

| | Худалдаа хөгжлийн банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2240.00 | 2253.00 | ФУНТ | 2907.00 | 3035.00 |
| ЕВРО | 2473.00 | 2584.00 | РУБЛЬ | 32.46 | 37.64 |
| ИЕН | 21.50 | 22.62 | ЮАНЬ | 335.50 | 339.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

УЛС ТӨР

АЙЛЧЛАЛ

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ХАГАС ЗУУН ЖИЛИЙН ДАРАА КУБА УЛСАД АЙЛЧИЛЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Бүгд Найрамдах Куба улсад хийх албан ёсны айлчлал хийлээ. Угтах ёслолын эхэнд Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Кубын үндэсний баатар Хосе Мартигийн хөшөөнд хүндэтгэл үзүүлж, цэцэг өргөв. Бүгд Найрамдах Куба Улсын Төрийн Зөвлөл болон Сайд нарын Зөвлөлийн дарга Раул Кастро Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийг албан ёсоор угтан авч, мэндчилсэний дараа Хүндэт харуулын дарга илтгэл өгч хоёр орны Төрийн дуулал эгшиглэдээ. Угтах ёслолд Монголын талаас УИХ-ын гишүүн, Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Монгол Улсаас БНКУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ц.Батбаяр, Кубын талаас БНКУ-ын Гадаад хэргийн сайдын үүрэг гүйцэтгэгч, Тэргүүн дэд сайд Марселино Медина, БНКУ-аас Монгол улсад суух Элчин сайд Раул Делгадо болон албаны төлөөлөгчид оролцсон байна. Монгол, Куба хоёр улсын улс төрийн харилцаа 1960 оны арванхоёрдугаар сард дипломат харилцаа тогтоож, 1962 оны долоо, есдүгээр сард харилцан бие биеийн нийслэлд ЭСЯ-аа нээснээр эхэлсэн аж. Улмаар 1990-ээд оноос өмнө социализмын жилүүдэд Монгол, Кубын хооронд нам, төрийн шугамаар бүх шатны төвшинд харилцан айлчлалыг өргөн хэрэгжүүлж байжээ. Үүнээс Монголын нам, төр, засгийн удирдагч Ю.Цэдэнбал 1972 онд, Ж.Батмөнх 1984 онд тус тус Куба Улсад, Кубын Коммунист намын хоёрдугаар нарийн бичгийн дарга, Батлан хамгаалахын сайд Раул Кастро 1970 онд Монгол Улсад хийсэн айлчлал голлох байр суурь эзэлдэг юм байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн энэхүү айлчлал нь дээрх айлчлалаас хойш хагас зуун жилийн дараа хийгдэж байгаа албан ёсны айлчлал гэдгээрээ онцлогтой.

## Ц.Элбэгдорж, Раул Кастро нар албан ёсны хэлэлцээ хийлээ

Айчлалын хүрээнд Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Бүгд Найрамдах Куба Улсын Төрийн Зөвлөл болон Сайд нарын Зөвлөлийн дарга Раул Кастро нар албан ёсны хэлэлцээ хийлээ. Уулзалтын эхэнд Эрхэмсэг ноён Раул Кастро Монгол Улсын Ерөнхийлөгч тэргүүтэй төлөөлөгчдийг албан ёсны айлчлал хийхээр хүрэлцэн ирсэнд талархал илэрхийлээд 1970 онд Монголд улсад айлчилж байсан дурсамжаасаа хуваалцаж, энэ тухай дурсахад үргэлж таатай байдаг тухайгаа ярилцсан байна. Тэрбээр манай хоёр улс дэлхийн бөмбөрцөгийн хоёр талд байдаг ч олон улсын тавцанд бие биеэ харилцан дэмжиж ирсэнд сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлж цаашид ч энэхүү уламжлалаа хадгалах нь чухал болохыг тэмдэглэв. Харин Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хэлэхдээ Эрхэмсэг ноён Раул Кастро болон найрсаг Кубын ард түмэнд найрсаг дотноор хүлээн авч буйд талархал илэрхийлээд Куба улс нь Латин Америкийн бүс нутгийн орнууд дотроос Монгол Улстай дипломат харилцаа тогтоосон анхны улс бөгөөд өнгөрсөн 50 гаруй жилийн хугацаанд хоёр орны найрсаг харилцаа батжин хөгжиж ирснийг онцжээ. Уулзалтын үеэр хоёр тал боловсролын салбар дахь хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэж ирснийг онцолж, Куба Улсын Засгийн газраас олон жилийн турш Монголын оюутан залууст олгож ирсэн тэтгэлэгийг цаашид нэмэгдүүлэхээр болсон байна. 1994 оноос Кубын засгийн газар жил бүр 2-3 оюутан шүдний эмч, хүний их эмч болон эмчилгээний чиглэлээр Монголын оюутан залууст сургалтын тэтгэлэг олгож эхэлсэн бөгөөд 2016 оны байдлаар 140 гаруй оюутан тэтгэлэгт хамрагдаад байгаа юм байна. Мөн хоёр орны хөдөө аж ахуй, биологийн болон байгалийн гаралтай бүтээгдэхүүн, эм, эмнэлэгийн салбарт хамтран ажиллахаар ярилцаж, Элэгний гепатит B,C вирусын эсрэг тарилга, сахарын өвчний сүүлийн шатны хөл шархлалтын эсрэг тарилгыг Монголд нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцож чадлаа. Албан ёсны хэлэлцээ болон уулзалт таван цаг гаруй үргэлжилж маш өргөн хүрээний сэдвээр санал солилцсон байна.

## Кубын биотехнологийн төвд зочиллоо

Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж айлчлалын хүрээнд Кубын “Генетикийн инженер, биотехнологийн төв”-д зочиллоо. Ерөнхийлөгчийг тус төвийн захирал Еүлохио Пиментел, “БиоКубаФарма”нэгдлийн Ерөнхийлөгч Др. Карлос Гутиеррес нар угтан авч төвийхөө үйл ажиллагааны талаар танилцуулжээ. Хөгжиж буй орнуудад их хэмжээгээр тархаж буй вирус, халдварт өвчинтэй тэмцэх зорилгоор “Генетикийн инженер, биотехнологийн төв”-ийг тухайн үеийн Ерөнхийлөгч Фидэл Кастрогийн санаачилгаар 1982 онд үүсгэн байгуулж байсан түүхтэй юм байна. Элэгний гепатит B,C вирусын эсрэг Интерферон, сахарын өвчний сүүлийн шатны хөл шархлалтын эсрэг Хеберфрот тарианаас гадна менингит зэрэг олон төрлийн өвчний эсрэг эм үйлдвэрлэн, дэлхийн 38 оронд экспортлон худалдаалдаг бөгөөд Санкти Спирито, Камагуэе хотуудад салбартай, Гавана дахь төвдөө 13 лаборатор, 350 гаруй үндсэн ажилтантай Био-анагаах ухааны судалгааны хэсэг, Геном ба дархлаа оношлогооны газар, Шинжлэх ухаан техникийн болон судалгааны тэнхимүүдэд хуваагддаг юм байна. Тус тэнхим нь өвчний угийг судлаж, сөрөг молекулуудын химийн бодисын тэсвэрийг биоинформатик ба протеомик аргаар тодорхойлон, шинэ эмийн найрлага боловсруулдаг. Одоогоор уургийн молекул, биоинформатикийн сурдалгаа, ДОХ-ын вирусын эсрэг молекулын судалгаа, дархлаа бууралтын эсрэг судалгаа, хөхний булчирхайн судалгаа зэрэг 10 орчим нэр төрлийн судалгааг явуулдаг аж. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж тус төвийн захирал Еүлохио Пиментел болон зарим эрдэмтэдийг Монголд урьж хөдөө аж ахуй, эм, эмнэлэгийн салбарт хамтран ажиллах чиглэлд дэмжлэг үзүүлнэ гэдгээ илэрхийлсэн байна.

# УИХ-ЫН ДАРГА ЦЭДЭНБАЛ АГСНЫ ХҮҮГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ

УИХ-ын дарга М.Энхболд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Сайд нарын зөвлөлийн дарга асан, БНМАУ-ын баатар, Хөдөлмөрийн баатар, БНМАУ-ын Маршал Юмжаагийн Цэдэнбал агсны хүү Ц.Зоригт хүндэтгэл үзүүлж, гэр бүлийнх нь хамт хүлээн авч уулзлаа. Уулзалтын эхэнд УИХ-ын дарга М.Энхболд эрхэм зочидтой уулзсандаа баяртай байгаагаа илэрхийлээд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Сайд нарын зөвлөлийн дарга асан, БНМАУ-ын баатар, Хөдөлмөрийн баатар, БНМАУ-ын Маршал Юмжаагийн Цэдэнбалын мэндэлсний 100 жилийн ойн мэндийг түүний хүү, гэр бүлд нь дэвшүүллээ. Мөн тэрбээр “Монгол Улсын Их Хурлын ээлжит бус чуулган хуралдаж, долоо хоногийн өмнө өндөрлөлөө. Ээлжит бус чуулганаар “Юмжаагийн Цэдэнбал агсны алдар гавьяаг мөнхжүүлж, түүний мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталж, Монголын төр, ард түмэн нийтээр энэ ойг тэмдэглэн өнгөрүүлэх нь зүйтэй гэсэн шийдвэрийг гаргасан. Энэхүү ойн арга



хэмжээг зохион байгуулах ажлыг УИХ-ын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат хариуцаад ажиллаж байна. Уг ойн арга хэмжээ гурван өдрийн турш болох төдийгүй хөдөө орон нутагт бид намынхаа шугамаар тодорхой ажлуудыг хийхээр төлөвлөсөн байгаа. Энэ удаагийн УИХ-ын шийдвэр бол Монголын төрийг 44 жил удирдаж явсан Ю.Цэдэнбал агсны ажил үйлс, амьдрал, Монгол төрийн төлөө зүтгэж явсан бүх зүйлийг бодитоор үнэлэн дүгнэж, хойч үедээ өвлүүлэх зорилготой. Энэ хүний Монголын төрийг удирдаж явсан тэртээх он жилүүдэд монголчууд бичиг үсэгтэй болж, эрүүлжин гэгээрч, үйлдвэржиж, НҮБ-ын гишүүн болж, жинхэнэ ёсоор тусгаар тогтносон улс болсон. XX зуунд Монгол Улс хөгжин дэвжиж, цэцэглэн мандсан бүхий л үйл хэргийг энэ эрхэм хүн удирдан жолоодсон гэдгийг монголчууд мартахгүй байхын учир УИХ-ын тогтоолыг баталсан” хэмээгээд Ю.Цэдэнбалын музейг байгуулахаар болсныг дуулгав. Харин Ю.Цэдэнбал агсны хүү Ц.Зориг УИХ-ын даргад хүлээн авч уулзаж байгаад нь талархаж байгаагаа илэрхийлээд Монгол Ардын Намыг УИХ-ын ээлжит сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулсанд баяр хүргэв.

## АН-ын сонгуулийн штабыг Д.Эрдэнэбат удирдана

Ардчилсан намын Гүйцэтгэх зөвлөл хуралдж, өнгөрсөн баасан гарагт товлогдсон байсан Үндэсний зөвлөлдөх хорооны хуралдааныг хойшлуулсан. Түүнчлэн сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны сонгуульд Ардчилсан намыг удирдан оролцуулах сонгуулийн менежерээр УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбатыг томилж, сонгуулийн штаб байгуулж ажиллахыг үүрэг болгоод байна. 2016 оны УИХ-ын сонгуульд Ардчилсан нам ялагдал хүлээсний дараа тус намын дарга З.Энхболд огцорч, Гүйцэтгэх зөвлөлийн хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбатыг тус намын даргын үүрэг гүйцэтгэгчээр томилсон байдаг.

Харин одоо орон нутгийн сонгуульд намаа удирдаж ажиллах үүргийг Гүйцэтгэх зөвлөлөөс хүлээлээ. Түүнийг 2008-2012 онд намынхаа ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байх үед Ардчилсан нам 2012 оны УИХ-ын сонгуулиас эхлэн орон нутгийн сонгууль, Ерөнхий сонгуульд тус бүр амжилттай оролцож байсан юм.

Дугаарын **60** мөр

## Группийн мөнгөнд “шургалсан” намчирхал

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Ер нь бол хөдөөд группийн мөнгийг таньдаг эмчээрээ магадлагаа бичүүлээд авдаг байдал хэрээс хэтэрчихсэн байсан. Худал хэлсэн хүнд цөөн хүн амтай жижиг сумын бүх иргэд группийн мөнгө авдаг байлаа. Хараа нь жаахан муу бол сохорчихсон мэтээр бичиг бичүүлээд л групп авна. Хөл нь жаахан доголдог бол хугараад, тасраад уначихсан, ажил хийх боломжгүй гэх мэтээр сүртэй магадлагаа таньдаг эмчээрээ бичүүлээд л төрөөс мөнгө “зулгаана”. Ингэж л халамжийг танил талаараа дамжуулж хавтгайруулж байлаа. Харин МАН-ын Засгийн газар энэ бүхнийг эмх цэгцэнд нь оруулж байгаа гэнэ ээ. Маш зөв зүйтэй алхам. Харин энэ зөв ажилд нэг буруу жишиг тогтоод байна гэнэ ээ, цаана чинь. УИХ-ын гишүүд, сайд дарга нарт огт хүртээлгүй, дунд шатанд завхруулдаг заваан жишиг хаа сайгүй байгаа. Тэр дундаа суманд. Тэгвэл Засгийн газраас хавтгайрсан халамжийг халж байгаа энэ зөв бодлогыг суманд завааруулж, МАН-ын гишүүн бол эрүүл байсан ч группт оруулж байна гэнэ. Харин АН-ын хүн бол өрөөсөн хөлтэй байсан ч группийнх нь мөнгийг хасаад, намаар нь хувааж буй сурагтай. Ийм заваан намчирхалаа болиулаач ээ, нөхдүүд ээ. Тэр дундаа дунд шатанд байгаа “хурган дарга” нарын хуудуутай, муйхар, тэнэглэл нь хэрээс хэтэрсэн үйлдлүүдийг хянадаг, цагддаг болмоор байна аа, гишүүд ээ. Төр засгийнхан нь хуралдаж хуралдаж, нэг шийдвэр гаргаад, зөв зүйтэй ажил хийх гэдэг. Гэтэл дунд шатандаа очоод л намчирхал, танил тал, авлига хээл хахуулын “тор”-нд орооцолдож, гацчихаад байна, тэр ажил чинь. Ерөөс бүхий л ажил дунд шатанд очиж замхардаг, балардаг жишиг улс орныг “алж” байна. Манайхан болохоор хэдэн гишүүд, сайд нартайгаа л үзээд байдаг. Гэтэл завсарт нь дунд шатны зувчуулаачид чинь төрийн ажлаар тоглож гүйцлээ. Угаасаа манай улсад халамжийн хавтгайрлыг халах цаг болсон. Бүгд ядуу болох гэж оролдож, танил талаараа дамжуулж бичиг цуглуулаад, халамж авдаг. Төрөөс өгч байгаа мөнгөөр гэдсээ цатгачихаад, юу ч хийхгүй хэвтэж байдаг нөхдүүд хаа сайгүй болчихсон. Тэр дундаа суманд. Тиймээс л сум орон нутаг хөгжиж, жижиг, дунд үйлдвэрлэл урагшаа ахихгүй байна. Хаанаас, ямар халамж өгч байна, тэр болгоныг ямар нэг аргаар аваад сурчихсан баячууд хүртэл байгаа шүү дээ. Энэ бүхнийг зоригтойхон халах нь зөв. Харин тэр бодлоготоо намчирхал хутгачих юм бол тэгээд л сүйрч байна гэсэн үг. АН намынх бол үгээгүй ядуу, өрөөсөн хөлтэй ч байсан халамжийг нь хасаад. МАН намынх бол өнгөтэй өөдтэй, өвчин зовлонгүй ч байсан халамжлаад явчихвал төрийн бодлого хадуурчихаж байгаагаас ялгаа юун. Эрхэм сайдууд, бодлого гаргагчид шийдвэр гаргачихаад, дараа нь дунд шатанд юу болж байгааг нэг хяначихдаг тогтолцоотой болмоор юм даа.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**Харилцах утас, факс: 976-70113551**

**“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

ҮЗЭЛ БОДОЛ







# ДАВХАР БАЙШИНТАЙ УЛААН ХИВСТЭЙ НЬ МАН, БАЙШИНГИЙН БУЛАНД ХОРГОДОЖ БАЙГАА АН

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

МАН энэ удаад лидергүйдэн балмагдаж байж мэднэ. Д.Дэмбэрэл, Ж.Бадамжунай мэтийн луйхаруудтай тэнцэхүйц залуучуудын нэрийг дэвшүүлсэн бол тэр хэрээр сонирхолтой, жинхэнэ сонгууль болох байлаа, үнэнийг хэлэхэд. МАН-ын мөнгө төгрөгтэй хийгээд олонд танигдсан залуу идэр улстөрчдийнх нь дийлэнх УИХ болоод нийслэлд нэр дэвшин байр суурийг эзлэн УИХ-ын гишүүн цаашлаад сайд, дарга болоод амжсан. Тиймээс орон нутагт томчуудын ар талд ажилласан бэлтгэл хангагчид л нэр дэвшиж буй. Тэдний халаас хоосон учраас ар талд ажилласан нь ойлгомжтой. Ийм нөхдүүдээс бүрдэх намын санхүүжилт ямар байх нь ч мэдээжийн зүйл. Орох орон, унаж яваа машинаа барьцаат зээлийн газарт тавиад ч болов сурталчилгаагаа явуулах юм гэнэ. Тийм нөхдүүд орон нутгийг үнэн сэтгэлээсээ удирдаж чадах нь эргэлзээтэй. Яг ийм босготой орон нутгийн тогоо руу АН өнгийнө. Зарим талаар хөнгөн зууш мэт санагдаж болох ч ард түмэн оньгүй. Буруу сонголт хийснээ ухаарч, орон нутгийн сонгуулиар засч залруулахыг хичээнэ эсвэл алдаа оноог нь МАН-д үүрүүлсэн шиг үүрүүлье гээд тэр чигээр нь зүтгүүлж ч мэднэ. Ямартай ч улс төрийн хүчнүүд бэлтгэлээ базааж, өөр өөрсдийн "сум"-аа тавьж эхэлжээ. Нийслэлийн зургаан дүүрэгт тугаа хийсгэсэн улс төрийн хоёр хүчний намын хороодын үйл ажиллагаатай танилцан хоёр өдөр бэдэрхэд хоёр өөр өнгийн дүр зураг бүхий амьдрал угтаж байсныг нь энд дурдах ёстой байх. МАН олон жил Засгийн эрхийг барьсан, намын анхан шатны нэгжээ ч бодлогоор авч явж, материаллаг баазыг нь цаг ямагт бэхжүүлж ирснийг нь дүүрэг бүрт орших намын байрны байршил, барилгын хийц загвар, гадна, дотно тохижилт зэргээс нь харж болохоор бол Ардчилсан хувьсгалаас хойш ихэнхдээ гудамжинд лааз өшиглөж яваа АН-ын хувьд туг хийсгэх түрээсийн ч болов байртай байгаа нь их юм аж. Сонгуулийн сурталчилгаа эхлэх өдөр хариугүй хаалга цохих гэж байхад л их засвар хийж байгаа гээд будаг шохой үнэртүүлж, гишүүд, нэр дэвшигчдийгээ гудамжны буланд шахам цуглуулан хуралдах дээрээ тулж байх жишээний. Гэхдээ намуудын гал тогоо руу өнгийх аваас эв нэгдэл, зохион байгуулалт, албан тушаал, сандал ширээний төлөөх тэмцэл хэн хэнд нь л байх юм гээч. Муу нэртэй луу данстайгаараа дан ганц АН ч ийм байдаг юм биш аж.

## Байр суурийн төлөөх тулаан МАН–д байна

МАН бага хурлаараа Орон нутгийн ИТХ-д нэр дэвшиж өрсөлдөх улстөрчдийнхөө нэрийг тодруулж, тойргийг нь хэдийнэ хуваарилж өгчээ. Орон нутгийн сонгуулийг удирдах ерөнхий менежер хийгээд сум, дүүргийн менежерүүдээ сонгон, намын хороод хуралдан, сонгуулийн хугацаанд ямар тактикаар ажиллахаа хэлэлцэж тодорхойлоод амжиж. МАН-ыг боловсон хүчин, бааз суурийн хувьд хангалттай хэмээдэг ч УИХ-ын ээлжит сонгуулийн дараа намын хороодын дарга нар нь УИХ-д заларч одсон тул голомтоо сахиж үлдсэн гишүүд нь байр суурь, нэр төрийн төлөөх тулаанд АН-ын адил мордоцгоосон нь дүүргүүдийн намын хороодын өдөр тутмын байдлаас харж болохоор. Жишээ нь, Сүхбаатар дүүргийн МАН-ын хороо гэхэд л өөрийн байр савтайн дээр тохижилт, ширээ сандал, техник тоног төхөөрөмжийн хангалт энэ тэрийн тухайд ярих юм алга. Бүх зүйл нь бэлэн, зэлэн. Гагцхүү намын үүр нь хоёр хуваагдчихаад баларч байгаа аж. Намын хорооны дарга асан н.Төмөрбаатар нь гишүүдээ хоёр хувааж орхисон юм байх. Сонгуулийн ерөнхий менежер нь нэр дэвшигчдээ цуглуулж хуралдах гэж гурвантаа зар тарааж оролдоод тусыг эс олжээ. Бага хурлаас нэр дэвших нь тодорхой болсон дөрвөн нэр дэвшигч нь хуучин даргаа санагалзсан юм байлгүй, хаана, юу хийж яваа нь өнөө хэр тодорхойгүй байгаа гэнэ. Иймэрхүү дүр зураг бүхий байр суурь, сандал ширээ, албан тушаалын төлөөх тулаан улс төрийн хоёр хүчний аль алинд байгаа сурагтай.

Уг нь МАН-д сонгогчид ихээхэн итгэл хүлээлгэж байсан юмсан. Засгийн эрхийг авмагцаа л улсын төсвийг хэмнэнэ, тэрхүү хэмнэлт дарга нараас эхлэнэ хэмээн сүрийг үзүүлж, дэвхцсэн ч 60 хоногийн дотор хэлснээсээ буцаж, АН-ын эхлүүлсэн, хэрэгжүүлсэн байр суурийг хүлээн зөвшөөрөөд байгаа. Энэ бүх үйлдэл нь МАН нэрийг барж буй. Ийм байхад МАН ялна гэж хэлэхэд хэцүүхэн л байна.

## АН–д боломжууд бий, гэвч...

АН-д ялах боломж уг нь бий. Харамсалтай нь орон нутгийн сонгууль хаянд ирчихээд байхад ҮЗХ-ныхоо ээлжит хурлыг ч хийж чадахгүй, хурлынхаа товыг гурвантаа хойшлуулчихаад суусцгааж буй. Баахан шинэчлэл ярьсан залуучууд л хэвлэлийн бага хурал зарлаж гүйлдээд байх юм. Тэднийг тоож байгаа хүн байгаа ч юм уу, үгүй ч юм уу, хэн мэдлээ. Ямартай ч АН-ын шинэ даргыг сонгох марафон үргэлжилсээр орон нутгийн сонгуультай залгав. Даргын асуудал түүгээрээ шийдэгдэх биз гээд орхилоо гэхэд нийслэлийн АН эзэнгүйдээд балрах дээрээ тулаад байгааг юу ч гэж ойлгомоор юм. Нийслэлийг хэн удирдаж, орон нутгийн сонгуульд орох асуудал өнөө хэр бүрхэг хэвээр. Явж явж бор халзан хонь гэгчээр өнөө муу Э.Бат –Үүлийг л гэх байх. Үнэндээ ч түүнийг нийслэлчүүд санаж "үхэцгээх" гэж буй. Утаат улаанбаатарчуудын амьдралыг шинэчлэхийн төлөө санаачилсан, хэрэгжүүлсэн төслүүд таг зогссонд иргэд ихээхэн бухимдацгааж байгаа билээ. Хашаагаа орон сууцаар солих хүсэлтэй гэр хорооллынхон АН-д саналаа өгнө гээд дэвхэцгээж буй. Сургалтын төлбөрөө төлж чадахгүйд хүрч жилийн чөлөө авахаас өөр аргагүйд хүрсэн оюутнууд "Сайн оюутан" хөтөлбөрийг хэдийнэ санагалзаад эхэлжээ. Харамсалтай нь тэр бүхний автор гэж хэлж болох Э.Бат-Үүлийг Эрүүгийн цагдаагийнхан барьж хорих гээд байгаа. Дээрээс нь АН-ын нэр дэвшигчдийг орон нутаг дахь сонгуулийн хороо хоёр гурваар нь хасаад хаячихсан байдаг. Яах вэ, энэ асуудал өнөөдөр эцэслэн шийдэгдэж, үнэн ялах биз. МАН энэ мэт асуудлаар хөөцөлдөх нь нэр хүндэд нь сөргөөр нөлөөлнө гэдгийг пиарчид нь зөвлөдөггүй л юм байх даа. Аливаа зүйлийн төлөө хэт улайрах ч гал өөр дээрээ дууддаг гэмтэй.

Ер нь орон нутгийн сонгуулийн өмнөх дүр зураг иймэрхүү л янзтай байна. Гэхдээ 60 чавганц уралдахад нэг нь түрүүлдгийн жишгээр хэн нэгнийг нь ард түмэн сонгох нь дамжиггүй. Тэр нь харин хэн байх юм, орон нутгийг улс төрийн аль хүчин удирдах юм бэ гэдгийг одоогоор таашгүй.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




*БНМАУ-ын баатар, Хөдөлмөрийн баатар, БНМАУ-ын Маршал Юмжаагийн Цэдэнбалын хүү*

*Ц.Зориг*

18 дахь жилдээ МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины IV улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд 64 дугаар

ЗАХИАЛГЫН ҮНЭ 18000

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай post: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

## УЛС ТӨР

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ



# А.ИШДОРЖ:

## АЙМГИЙНХАА ХӨТӨЛБӨРИЙГ ЗАСГИЙН ГАЗРЫНХТАЙ УЯЛДУУЛААД ЯВНА ГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ БАЙНА

*Өвөрхангай аймгийн ИТХ-ын дарга А.Ишдоржтой цаг үеийн сэдвээр ярилцлаа.*

...Гадаад харилцааны яамнаас гэхэд л гадаад улс орнуудтай харилцахдаа яамаар дамжуулах, гэрээ хэлцэл хийхдээ мэдэгдэх гэх мэт чиглэлүүдийг өгч байна. Ажил аваад сар гаруйхан болж байгаа болохоор төсөл хөтөлбөр хөөцөлдөөд хэрэгжүүлчихсэн гэх зүйл алга. Өмнө нь хэрэгжиж байсан төсөл хөтөлбөрүүд бий...

**-Өвөрхангай аймагт зуншлага хэр болов. Одоо сайхан намаржиж байна уу. Өвөлжилтийн бэлтгэл ажилдаа орчихсон уу?**

-Ерөнхийдөаө манай аймагт зуншлага сайхан болсон. Малчид маань боломжоороо гар тэжээл, хадлангаа аваад өвөлжилтөд бэлтгэж байна. Монгол Улсын Засгийн газар болон Онцгой байдлын газрын албан даалгаврын хүрээнд бүх сум, багуудад өвс тэжээл бэлтгэх хуваарь гаргаад, үүрэг даалгавар өгөөд ажиллаж байна. Хадлан бол боломжийн хэмжээнд байна. Аймгийн Гучин-Ус, Төгрөг сумдаар зуншлага жаахан оройтсон боловч сүүлд бороо орж, нэлээд гайгүй болсон.

**-Ерөнхийдөө бороо хур хэр байв. Өмнөх жилүүдийнхтэй харьцуулахад...?**

-Бороо хур элбэг, нэлээд гайгүй байсны хүчинд хадлан авах бололцоотой байна.

**-Өвөрхангай аймгийн хувьд нэлээд асуудал үүсээд байгаа шүү дээ. Тэр дундаа малчдад нэлээд асуудал тулгамдаад байх шиг байна. Гол ус бохирдсон, бэлчээргүй болсон гээд л?**

-Манай аймаг өнгөрсөн жил малын тоогоороо улсад тэргүүлсэн. Хамгийн олон малтай аймаг боллоо. Түүнчлэн зөвхөн Өвөрхангай аймаг гэлтгүй улсын хэмжээнд малын тоо толгой өсч байна. Үүнтэй холбогдуулаад бэлчээрийн даацын асуудал үүсч, малчид хоорондоо бэлчээрээ булаацалдах асуудал гарч байна. Энэ асуудлыг шийдэхийн тулд малын тоо толгойг зохистой хэмжээнд барих, гадагшаа зах зээлд борлуулах зэрэг боломж бололцоог бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа. Өвөрхангай бол малын халдварт өвчин гардаггүй, тайван бүс. Халдварт өвчингүй, тайван бүс гэж баруун аймгуудаасаа ялгарсан. Тиймээс гадаад зах зээлд мах гаргах бүрэн боломжтой. Түүнчлэн энэ жил алдарт бичин жил тохиож байна. Цас зуд ихтэй байвал нэг, хоёрхон сарын дотор мал байхгүй болж, малчдын амьдрал хүнд болж болзошгүй. Тэгэхээр малыг борлуулах тал дээр нэлээд анхаарч, зохион байгуулах шаардлагатай гэж бодож байна.

**-Бэлчээрээс гадна уул уурхайн олборлолт, алтны компаниуд танай нутагт ихээр үйл ажиллагаа явуулж байна. Хор уршиг их гарч байгаа талаар ч байнга мэдээлэл цацагдаж байна. Энэ тал дээр?**

-Аймгийн хэмжээнд тулгамдаж буй хоёр дахь асуудал гэвэл алтны компаниудын нөлөөгөөр Орхон гол бохирдож байгаа асуудал байна. Орхон гол маань Монгол Улсын хамгийн урт гол, 1224 км урсдаг, Байгаль нуурт цутгадаг. Орхон голын эх маань Архангай аймгийн Цэнхэр сум, төрийн тахилгат Суварга хайрхнаас эх авдаг. Мөн Орхон голын эх бүрдэх Шийрт, Өлт, Тээл, Бодонт, Харгуйт зэрэг хөндий байж байгаа. Гэтэл энэ Шийртийн уурхай дээр 2-3 лицензийг өнгөрсөн жил Ч.Сайханбилэг Ерөнхий сайд байхдаа сэргээсэн байдаг. Урт нэртэй хуулиас гаргаж, сэргээсэн гэсэн үг шүү дээ. Үүний нөлөөгөөр 40 гаруй уурхай ажиллаж байна. Энэ жил Орхон гол улаан хоормог болтлоо бохирдож, ус биш шороо, шавраар урсаж байна. Үүнээс гадна хөндий, тал гэхээргүй болтлоо сүйтгэгдэж, газрын хөрсийг эргүүлж, энд тэндгүй хэдэн метр өндөр болтол нь овоолсон шороо, шороогоо угаасан ус нь шуудуу, сувгаа халин улаан шар өнгийн зуурмаг болон урсаж байна. Хүн мал уух ямар ч арга байхгүй. Орхон гол долоон аймгийн 113 багийг дамжиж урсч байгаа. Нэг талдаа улс орны эдийн засаг хүнд байгаатай холбогдуулаад бид газрын баялгаа ашиглах ёстой гэж байгаа боловч яг бодит байдал дээр Шийртийн алтны уурхайгаас улс орны эдийн засагт ямар дэмжлэг үзүүлсэн юм бэ, Монголбанкинд хэчнээн хэмжээний алт тушаагаад, ямар валютын нөөц бүрдүүлчихсэн юм бэ гэдгийг тооцож үзэх хэрэгтэй. Нөгөө талдаа Орхон голын сав дагуух 113 багт амьдарч буй хүн ам, малын тоо толгойг тоолоод үзвэл хэчнээн тоо гарах вэ гэдэг маш том асуудал байна. Ер нь бол Монгол Улсын Үндсэн хуульд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасан байдаг. Энэ эрх ноцтойгоор зөрчигдөж байгаа юм. Уул уурхайгаа ашиглаж эдийн засгаа сэргээж болох ч нөгөө талдаа иргэдийнхээ аюулгүй байдал, амь насны асуудлыг гаргуунд нь гаргаж болохгүй. Бат-Өлзий сумын малчид, иргэд над руу байнга ярьж байна. Мал үхэж байна гэж. Хөдөө аж ахуйн яамнаас малыг эрүүлжүүлнэ гээд л том бодлого хөтөлбөр яриад л байдаг. Гэтэл энэ голоос ууж байгаа мал өвчилж байна. Өвчилсөн малынхаа сүү сааль, махыг идэж байгаа хүмүүс ямар байх вэ. Эдийн засгийн хувьд ч хүнд нөхцөл байдал үүсч байна шүү дээ. Тухайлбал, Орхоны сав дагуу зусч байгаа малчид доод тал нь 5-10 км газарт явж, ус зөөж ууж байна. Энэ мэтчилэн маш хүнд асуудал тулгараад байна. Тэгэхээр Монгол Улсад өнөөдөр хууль хэрэгжих цаг болсон. Нэгэнт Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай буюу урт нэртэй хуульд ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно гэсэн бол түүнийгээ хориглох л ёстой. Угтаа бол иргэд болоод байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй, гол ус бохирдуулахгүй, технологи стандартын дагуу нөхөн сэргээлтээ хийгээд явдаг хариуцлагатай уул уурхай байх юм бол түүнийг эсэргүүцээд байх юм алга. Улс орны эдийн засгийн хүндрэлээс гарах гэж гарц хайж байгаа энэ цаг үед бодлогыг нь дэмжилгүй яах вэ. Тэгэхдээ цаана нь улс орны бодлого хэрэгжүүлэх гэж байна гээд олон хүн мал хохироож болохгүй гэдгийг л хэлмээр байна.

**-Орон нутгийн удирдлагуудын зүгээс эдгээр алтны компаниудад шаардлага хүргүүлсэн үү. Холбогдох албаныхан хяналт шалгалт хийж, шаардлага тавьсан удаа бий юу. Ер нь хэчнээн тооны компани үйл ажиллагаа явуулаад байна вэ?**

-БОАЖЯ, УУЯ, МХЕГ, зарим ТББ-ын хамтарсан ажлын хэсэг Шийртийн алтны уурхайд ажилласан гэж байгаа боловч аймгийн удирдлагуудад огт мэдэгдээгүй. Уг нь гол бохирдож байгаа асуудал Өвөрхангай, Булган, Эрдэнэт, Дархан, Сэлэнгэ аймаг, цаашлаад магадгүй Байгаль нуур бохирдож байгаа эсэх тухай асуудал яригдаж байгаа. Гэтэл Орхон голын сав дагуу шалгалт хийхдээ бидэнд огт мэдэгдээгүй. Тийм учраас би БОАЖ-ын сайдаас тодруулж, асуусан. Ямар ч байсан дүн шинжилгээ нь гарч байгаа юм байна. Арга хэмжээ авсан юм байна. Гэтэл ер нь бол хяналт шалгалт яваад, бараг тоос нь далд ороогүй байхад л уул уурхайн компаниуд лацыг нь аваад л ажиллаж эхэлдэг. Тэгэхээр ярьж байгаа мэдээлэл, бодит байдал хоёр зарчмын зөрүүтэй байна гэж үзэж байгаа.

**-Орхон голд хэчнээн олон гол цутгадаг, дээрээс нь аялагч жуулчдын ихээр очдог Улаан цутгалан гэж байгалийн үзэсгэлэнт газар байдаг. Мөн Орхон голд загасчлахаар олон хүн очдог байсан шүү дээ. Одоо бүр загас жараахай ч үгүй болсон уу?**

-Би өөрөө Орхон гол дээр өссөн хүүхэд. Орхон голын дагуу эрт дээр үеэс хаад, ноёд нутаглаж ирсэн түүхтэй. Төрөл бүрийн загас жараахайтай, ус арвинтай гол байсан. Мөн Орхон голд хамгийн багадаа 40-50 том, жижиг голууд цутгадаг. Үүнийг дагаад Архангай аймгийн Цэнхэр сумын Орхон багийн Ихтээл, Өлзийттээл, Хошигт, Гүрд, Шивэртийн гол бүгд Орхон голд нийлдэг. Цааш нь Баянхонгор аймгийн Эрхэт, Тамч, Улиастайн гол Орхонтой нийлж урсдаг. Төв аймгийн Батцэнгэл, Өлзийт сумын урдуур урсдаг Орхон голтой Архангай аймгийн Тамирын гол нийлж урсана. Урд Тамирын гол эхэндээ Суварга хайрхан уулын зүүн суганаас эх авсан. Мөн олон жижиг булаг, шанд нийлсэн байдаг. Гэтэл одоо энэ олон булаг шанд бохирдох эх үүсвэр болоод байна. Мөн Орхон гол нэг ширхэг ч загас жараахай байхгүй. Тиймээс Орхон голын экологи, эдийн засгийн үнэлгээг тооцуулаад, загас жараахай, ус гол бохирдуулсан талаар аль ч шатны байгууллагад хандахад хангалттай хэмжээнд хариуцлага тооцох бүрэн боломж нөхцөл бий. Гэвч энэ асуудал дээр хөдлөхгүй байна уу, хөдлөх сонирхол байга байна уу даа гэж бодогдох юм. Аймаг орон нутгийн удирдлагууд бүгдээрээ л шинээр томилогдсон. Тэгэхээр одоо уулзаж, ярилцаж, шийдэлд хүрье гэсэн санал санаачилга гарч байна даа, эхнээсээ.

**-Улс орны эдийн засаг нэлээд хүнд байна. Танай аймгийн хувьд хэр байна. Аймгийн эдийн засгийн чадавхи, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө хэр хэмжээтэй байгаа вэ. Ирэх жилүүдэд аймгаа хөгжүүлэх, үйл ажиллагаа явуулахад хэдий хэрийн төсөв шаардлагатай байгаа вэ?**

-Өвөрхангай аймгийн тухайд төсвийн орлого харьцангуй гайгүй байгаа. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлууд санхүүжилт жаахан удаашралтай байгаа. Энэ бол улсын төсвөөс өгдөг учраас улсын төсвийн бүрдүүлэлттэй холбоотой дутмаг байгаа байх. Тэгэхдээ энэ хямралын үед аль болох өр үүсгэхгүй байх тал дээр хичээж ажиллана. Орон нутгийн хөгжлийн санд 2013 онд Өвөрхангай аймгийн хэмжээнд 13 орчим тэрбум төгрөг батлагдчихсан. Тэр жилдээ 30 хувийг нь өгөөгүй, дараа жил нь дахиад 40 хувийг нь хассан гээд л багасаад байгаа. Тэгэхдээ бага гэхгүй Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөрөө сумдын удирдлагууд заавал аймгийн удирдлагууд, Засгийн газарт хандахгүйгээр иргэдээрээ хэлэлцүүлж, нэн түрүүнд тулгамдаж буй чухал гэсэн асуудлаа сонгоод түүнийгээ хэрэгжүүлээд явах боломж бололцоо бол байгаа. Төсвийн сахилга батыг нэлээд сайн сахих цаг үе тохиож байна.

**-Аймгийн удирдлагууд солигдсонтой холбоотойгоор халаа сэлгээ хийгдэж эхэллээ. Зарим аймаг дээр намаар ялгаварлах асуудал хүртэл гарч байна. Танай аймгийн хувьд ийм асуудал гарч байна уу?**

-Манай аймаг улс төрийн хувьд харьцангуй тогтвортой. 1992 оноос хойш улс төрийн удирдлага нэг их өөрчлөгдөөгүй. Ер нь тогтвортой байх нь ч аймгийн хөгжилд үр нөлөөтэй юм. Аймгийн хөгжлийг ярьвал бусад аймгуудаас нэлээд дээгүүр төвшинд явж байгаа гэж хэлж чадна. УИХ-д гишүүнээр сонгогдсон Тогтохсүрэн дарга маань 16 жил Өвөрхангай аймгийн удирдлагаар ажилласан. Засаг дарга, ИТХ-ын даргаар тус бүр найман жил ажилласан. Энэ хүний тогтвортой удирдлагын үр дүнд аймаг хөгжиж байгаа. Ер нь хийж чадаж байгаа, тогтвортой, мэргэшсэн албан хаагчдыг аль болох өөрчлөхгүй байх нь чухал. Тиймээс Өвөрхангай аймагт халаа сэлгээний асуудал харьцангуй гайгүй. Босоо удирдлагатай ганц нэг газрууд дээрээсээ өөрчлөгдөх байх. Ер нь өнгөрсөн дөрвөн жил үүрэг гүйцэтгэгчээр янз бүрийн хүмүүсийг томилчихсон байсан. Эдгээр хүмүүсийн тухайд өөрчлөлт гарах байх.

**-Төсөв мөнгө хүндрэлтэй байгаа гэдэг утгаараа цалин мөнгө хэмнэх зорилгоор орон тооны цомхотгол хийх үү?**

-Босоо удирдлагатай хэлтэс, газрууд, аймгийн орон тоо, бүтэц, зохион байгуулалтыг баталж өгч байгаа. Тэр бүтэц, орон тоондоо л багтаана. Засгийн газраас тоог нь багасгаад баталж өгвөл цомхотгол хийхээс өөр арга байхгүй. Харин байгаа төвшиндөө юм уу, орон тоог багасгаагүй тохиолдолд цомхотгол хийгээд байх шаардлагагүй.

**-Тансаг хэрэглээг танана, зардлаа хэмнэнэ гээд л байгаа. Аймгийн хувьд зардлаа хэмнэх тал дээр хэр анхаарч байна?**

-Тансаг хэрэглээ гэдгийг юу гэж ойлгох вэ гэдгээс л асуудал шийдэгдэх байх. Ер нь тэгээд ч аймгийн удирдлагууд гадаад руу яваад л, үрэн таран хийгээд байдаг юм байхгүй. Албан ёсны дагуу гадаад харилцаатай ганц нэг улс руу, Засгийн газрын багт багтаад жилдээ 1-2 удаа явах тохиолдол байдаг. Түүнээс биш байнга гадаад руу зугаалаад, яваад байх боломж байдаггүй. Тийм зардал бага. Сахилга батын хувьд манай аймаг харьцангуй сайн шүү.

**-Гадны төсөл хөтөлбөрүүдийг орон нутаг руугаа татах тал дээр хэр ажиллаж байна?**

-Нэлээд сайшааж ажиллах бодолтой байгаа. Яамдын удирдлагуудтай уулзаад явж байхад нэлээд чиглэл өгч байна. Гадаад харилцааны яамнаас гэхэд л гадаад улс орнуудтай харилцахдаа яамаар дамжуулах, гэрээ хэлцэл хийхдээ мэдэгдэх гэх мэт чиглэлүүдийг өгч байна. Ажил аваад сар гаруйхан болж байгаа болохоор төсөл хөтөлбөр хөөцөлдөөд хэрэгжүүлчихсэн гэх зүйл алга. Өмнө нь хэрэгжиж байсан төсөл хөтөлбөрүүд бий.

**-Орон нутгийн сонгууль хаяанд ирлээ. Бэлтгэл ажил нь хэр явагдаж байна?**

-Хуулийн дагуу бүх сонгуулийн хороод байгуулагдаад, улс төрийн намууд нэр дэвшигчдээ тодруулж, мөрийн хөтөлбөрөө аудитын байгууллагад өгөх зэргээр графикийн дагуу л явагдаж байна. Өмнөх сонгууль арваннэгдүгээр сард болж, цас орчихсон, гол ус зайрмагтчихсан нэлээд хүйтэн байх үед болж байсан болохоор ирц хүрэх болов уу яах бол гэж байсан. Харин энэ жилийн хувьд аравдугаар сард болж байгаа болохоор харьцангуй гайгүй байна байх.

**-Танай аймгийн хувьд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нэлээд боломжтой. Түүнчлэн түүхийн дурсгалт газрууд ч олон байдаг шүү дээ. Энэ тал дээр хэр анхаарал хандуулж ажиллах вэ?**

-Монгол Улсын төвийн бүсийн аялал жуулчлал Хархорин, Хужирт, Орхоны Улаан цутгалан, Төвхөн хийд гээд Архангай аймаг руу ордог. Өвөрхангай аймагт аялал жуулчлалын томоохон бодлого бий. Манай аймагт эртний үлэг гүрвэлийн яс, өндөг, чулуужсан модтой хэсэг байна. Тиймээс бид баруун болон говийн чиглэл, зүүн чиглэлд Их соён гэгээрүүлэгч, Өндөр гэгээн Занабазарын мэндэлсэн Есөнзүйл сум, Улаанбаатар хотын шав тавьж байсан Ширээ цагаан нуур гэх мэтчилэн түүхийн дурсгалт газар арвинтай нутаг. Тиймээс аймаг дотроо гурван бүс болгож, аялал жуулчлалаа хөгжүүлье гэж бодож байгаа. Энэ жилийн хувьд Орхон голын сав дагуу аялал жуулчлал хөгжихөд тулгамдаж байгаа нэг гол асуудал, тэнд очиж байгаа иргэдийн сэтгэл эмзэглэж, халаглаж байгаа зүйлүүд бол сая ярьсан Орхон голын бохирдол. Орхоны зах дээр тав тухтай ирээд, сайхан амарчихъя гэхээр амрах, усанд орох, уух ямар ч боломжгүй. Тэнд очсон гадна, дотны иргэд маш ихээр шүүмжилж байгаа. Тийм учраас Орхон голоо л бид амийг нь тасалчихалгүй авч үлдэж, бохирдлын асуудлыг бүрэн шийдчих юм бол аялал жуулчлал хөгжих бүрэн боломж бий. Цаашид аялал жуулчлалыг хөгжүүлэх тал дээр БОАЖ-ын сайдад санал тавих бодолтой байгаа.

**-Өвөрхангай аймгийн ИТХ-ын дарга А.Ишдорж гэдэг хүний талаар манай уншигчид сонирхож байгаа байх. Ямар залуу, ямар зорилготой хүн аймгийн ИТХ-ын даргаар томилогдчихов гээд харж байгаа байх. Өөрийгөө манай уншигчдад танилцуулахгүй юу?**

-Би Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын харьяат, энэ нутаг усны унаган хүү. Физик, байгаль шинжлэлийн багш мэргэжилтэй. 1999 онд МУБИС-ийг төгсөөд, Бат-Өлзий сумынхаа сургуульд багшилсан. Мөн 2000-2004 онд сумынхаа Соёлын төвийн эрхлэгч, Хүүхэд залуучуудын ажилтан, 2004-2011 он хүртэл Бат-Өлзий сумын Засаг даргаар ажилласан. 2011 оноос аймгийн төв, Арвайхээр сумын Засаг дарга, хотын захирагчаар ажилласан. Нийтдээ 12 жил төрөлх нутагтаа, сумын Засаг даргаар ажиллалаа. Хөдөөгийн хүн ам ихтэй сум, аймгийн төвийн хүн ам ихтэй сум гээд төрийн албыг анхан шатнаас нь хашиж, суралцаж явна даа. Тэгээд энэ удаагийн сонгуулиар ИТХ гээд аймгийн бодлого тодорхойлох томоохон байгууллагад аймгийнхаа ИТХ-ын төлөөлөгчдийн 100 хувийн саналаар дэмжигдэж гарч ирлээ. Их олон зүйлийг хийхээр бодож төлөвлөж байгаа. Аймаг, орон нутгаа эдийн засгийн хувьд яаж бие даалгах вэ, санхүүгийн хувьд яаж бэхжүүлэх вэ гээд бодсон зүйлүүд байна. Аймгийн ИТХ-ын хоёр дахь том бүрэн эрхийн том хуралдаан болно. Энэхүү хуралдаанаар аймгийн Засаг даргын ирэх дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг батална. Засгийн газрын мөрийн хөтөлбөртэйгөө аймгийнхаа хөтөлбөрийг уялдуулаад явна гэсэн төлөвлөгөөтэй байна.

ТОМИЛОЛТ

# ЕРӨНХИЙ САЙД Ж.ЭРДЭНЭБАТ СЭЛЭНГЭ, ДАРХАН-УУЛ АЙМАГТ АЖИЛЛАЛАА



**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Засгийн газар дэмжиж ажиллана гэж байлаа. Хөдөө аж ахуйн салбарт илүү амжилт гаргах хэд хэдэн хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

## Үр тариа худалдан авах хүмүүст дэмжлэг үзүүлнэ

Ургацын урьдчилсан балансаар 501.0 мянган тн үр тариа, үүнээс 482.1 мянган тн буудай, 174.7 мянган тн төмс, 117.5 мянган тн хүнсний ногоо, 32.5 мянган тн тосны ургамал, 43.4 мянган тн малын тэжээлийн ургамал тус тус хураан авна. Манай улсын жилийн хэрэгцээт гурилыг дотооддоо үйлдвэрлэхэд 320 мянган тн цэвэр хүнсний улаан буудай шаардлагатай байдаг. Балансаас харахад 2016-2017 оны гурилын хэрэгцээг бүрэн хангах хэмжээний буудайн нөөц бүрдэхээр байна. Энэ жилийн хувьд байгаль цаг агаар таатай, өндөр ургац авах боломж байгаа ч тариалалтын явц хангалалттай биш байна. Тухайлбал, Сэлэнгэ аймаг арав, Дархан-Уул аймгийн ургац хураалт 20 гаруй хувьтай байгааг орон нутгийн удирдлагууд өгч байна. Ойрын өдрүүдийнх шиг цаг агаар тааламжтай өдрүүд үргэлжилбэл ургац хураалт тодорхой хэмжээнд нэмэгдэнэ. Тариаланчид өөрсдөөс шалтгаалах бүхий л бэлтгэлээ хангажээ.

Тариаланчид ургацаа борлуулах асуудалд төр засгийн зүгээс дэмжлэг үзүүлэхийг хүсч байсан юм. Засгийн газар тариаланчдын хүсэлтийг үндэслэж энэ оны төсвийн тодотголд зургаан тэрбум төгрөгийн эх үүсвэрийг суулгасан. Энэ мөнгөөр үр тариа худалдан авахгүй, харин тариа худалдан авах хүмүүст санхүүгийн эх үүсвэр босгоход нь дэмжлэг үзүүлбэл борлуулалтад нөлөөлнө гэдгийг Ерөнхий сайд хэлж байлаа. Тариалан эрхлэлтийг дэмжих санд 100 орчим мянган тн улаан буудай хадгалах бололцоо бүхий агуулах бий. Манай үр тариа эрхлэгчдийн зарим нь энэ санд өртэй. Тус сан өөрөндөө 40 орчим мянган тн буудай авах байх. Үлдсэн 60 орчим мянгыг нь худалдаж авна. Улсад худалдаж авах мөнгө өнөөдөртөө байхгүй, тэгэхээр буудайг хадгалах бололцоог бүрдүүлэх ёстой гэдгийг холбогдох хүмүүст Ерөнхий сайд үүрэг болгожээ. Энэ жилийн хувьд чийг ихтэй байсан учраас будааны чанар доголдож магадгүй. Улсын стандарт хангасан борлуулалт хийхэд тариаланчдад хүндрэл учрахаар байгааг тариаланчид хэлж байна.

## Ногоочид өөрсдийн гэсэн зоорьтой болох нь

Ногоочдын хувьд ч хүндрэл нь мөн л борлуулалтын асуудал. Тэд ногоогоо нийслэлд хүргэж нэг кг-ийг нь 200 төгрөгөөр ченжүүдэд өгдөг, үнэ хямдарснаас хавар, зуны их ажил нь үр дүнгээ өгдөггүй, хүн хүчний боломжоос шалтгаалж хотод болдог яармаг худалдаанд оролцож чаддаггүй. Ерөөсөө л гол асуудал нь энэ ажээ. Зээлийн хүү өндөр байгаа нь ногоогоо үнэ хүргэж чаддаггүй нь тэдэнд хүнд тусдаг байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт газар тариалангийн даатгалын эрх зүйн орчин бий болгоно. Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих "Итгэлийн зээл" олгож, үйлдвэрлэл эрхлэх бололцоогоор хангах зорилт туссан. Үндэсний үйлдвэрлэл, аж ахуйн нэгжүүдээ дэмжиж, эх орныхоо хөрсөнд ургасан төмс, хүнсний ногоо худалдан авч хэрэглэж байхыг иргэддээ уриална гэдгийг Ерөнхий сайд хэлж байлаа. Ногоочдын хувьд ганцхан намрын улиралд бус бүтэн жилийн турш төмс, хүнсний ногоогоо борлуулдаг байвал амьдрал ахуйд нь дэмтэй. Жилийн хэрэгцээг хангах ногоо тариалсан ногоочид нэг өдөр, нэг сард бүгдийг нь борлуулна гэдэг хүндрэлтэй. Ногооны төвлөрсөн зоорьтой л болох ёстой. Ингэхгүй бол хадгалах байр савтай хүмүүс ногоог нь маш хямд үнээр худалдаж аваад өвөл, хаврын цагт үнэд орохоор нь зардаг энэ байдал үргэлжилнэ. Иймээс "Итгэлийн зээл" олгох чиглэлд Засгийн газар анхаарна. Энэ зээлээр үрийн аж ахуй байгуулж, шинэ сортын үрийн ногоо тариалж, импортын төмс, хүнсний ногоотой үнэ, чанараар өрсөлдөх ёстой гэдгийг захиж явлаа.

Дархан-Уул аймгийн Орхон сумын нийт хүн амын 80 орчим хувь нь төмс, хүнсний ногоо тариалж, жилд 10-16 мянган тн ургац авч, улсын нийт ургацын 10 гаруй хувийг хангадаг байна. Жимс ногооны гэж алдаршсан Орхон энэ сумынхан "Орхон кластер" нэртэй шингэн бүтээгдэхүүн, жимс жимсгэний төрөл бүрийн ундаа үйлдвэрлэх, ногооны салат, өргөст хэмх дарах, савлах тоног төхөөрөмж бүхий сав баглааны цогц үйлдвэрлэл байгуулах хүсэлтээ Ерөнхий сайдад гардуулсан.

## Иргэд "Насны хишиг" тэтгэврийг дэмжиж байна

Эдийн засгийн байдал хүнд нөхцөлд байна. Энэ хүндрэлээс гарах төлөвлөгөөг ойрын хугацаанд боловсруулж ажиллана гэж Ерөнхий сайд ярьж байна. Газар тариалангийн даатгалын эрх зүйн орчин бий болгоно. Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ. Гадаадын хөрөнгө оруулагчдыг татах бодлого явуулна. 1072 хувьцааг амилуулна зэрэг Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт туссан олон ажил Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт багтжээ. Иргэдийн уулзалт бүрт давтагдсан асуудал бол Хамтын тэтгэврийн тухай хуулийг хүчингүй болгосон тухай байлаа. Монгол Улсын хэмжээнд өнөөдөр 300 гаруй мянган ахмад настан тэтгэвэр авдаг. Хань ижлээ алдсан 77 мянга орчим ахмад бий гэсэн судалгаа байдаг. Хамтын тэтгэврийн хууль бол энэ 77 мянган ахмадын дөнгөж 10 хувьд нь л үйлчлэх хууль. Иймээс ахмад настан бүрийг хамруулах "Насны хишиг" тэтгэврийг дэмжиж байгаагаа иргэд хэлж байлаа. "Насны хишиг" тэтгэврийг ирэх жилээс олгохоор төлөвлөжээ.

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

# УБТЗ Ю.ЦЭДЭНБАЛ АГСНЫ ВАГОНЫГ МӨНХИЙН ЗОГСООЛД ЗАЛАВ

Э.МӨНХ

Монгол Улсын төр нийгмийн нэрт зүтгэлтэн, БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар, маршал Ю.Цэдэнбал агсны мэндэлсний 100 жилийн ойд зориулан түүний хэрэглэж байсан тусгай вагоныг Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг УБТЗ-ын дарга Л.Пүрэвбаатарын санаачилгаар Улаанбаатар суудлын вагон депогийн хамт олон иж бүрэн засварлаж, "Зочны өргөө" нэртэйгээр "мөнхийн зогсоол"-д нь хүлээлгэн өглөө. Энэхүү нээлтийн арга хэмжээнд УИХ-ын гишүүн, ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат, УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар, Н.Цэрэнбат, Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Б.Цогтгэрэл, УБТЗ-ын дарга Л.Пүрэвбаатар, УБТЗ-ын даргын зөвлөх Р.Раш, Т.Очирхүү, Ю.Цэдэнбал агсаны хүү Ц.Зориг болон "Ю.Цэдэнбал академи"-ийн тэргүүлэгч гишүүд оролцов. Тус арга хэмжээг УБТЗ-ын дарга Л.Пүрэвбаатар нээж үг хэллээ. Тэрбээр "Ю.Цэдэнбал нь Монгол Улсын түүхэн хөгжлийн хугацаанд БНМАУ-ын Сангийн яамны сайд бөгөөд Монгол банкны дарга, Сайд нарын зөвлөлийн дарга гээд улс орны хөгжлийн түүчээ болж, түүхэн үүрэг гүйцэтгэсэн төр, нийгэм, цэргийн нэрт зүтгэлтэн билээ. Тэрээр 1952 онд Замын-Үүдийн чиглэлд төмөр зам тавих ажилд биечлэн оролцсон түүхтэй. УБТЗ-ыг урагш сунгаж улсын өмнөд хил хүргэх ажил нь гурван улсын хэлэлцээрийн дагуу амжилттай хэрэгжсэнээр ОХУ, БНМАУ, БНХАУ-ын хооронд шууд харилцаа нээгдсэн төдийгүй өнөөдрийн Ази-Европыг холбосон төмөр замын тээврийн хамгийн дөт коридор баригдсан түүхтэй. Төмөр зам дагаж улс орны томоохон бүтээн байгуулалтууд өрнөж, Дархан, Эрдэнэт, Шарын-гол, Шивээ-овоо, Бор-өндөр зэрэг хот суурин газрууд сүндэрлэн, үйлдвэрүүд байгуулагдан, хөгжлийн нэгэн шинэ үеийг Монголын талд түгээн дэлгэрүүлсэн юм. Хөгжлийн энэ түүхэн хугацаанд УБТЗ улсынхаа хамгийн том дэд бүтэц болон хөгжсөн. Энэ бүхэнд төр нийгэм, цэргийн нэрт зүтгэлтэн Ю.Цэдэнбал агсаны оруулсан хувь нэмэр хэмжээлшгүй их гэдгийг цохон тэмдэглэе" гэв.

Тэгш ойг нь тохиолдуулан Юмжаагийн Цэдэнбал агсаны алдар гавъяаг мөнхжүүлэх зорилгоор УИХ, Засгийн газраас тогтоолуудыг баталсан байдаг бөгөөд энэ сарын 15-аас эхлэн тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулж буй. Тухайлбал, Монголын үндэсний төв музейд "Алдар гавьяаны замнал" үзэсгэлэн, Тусгаар тогтнолын ордонд Ц.Жамбалсүрэн "Монгол цэргийн нэрт зүтгэлтэн Маршал Ю.Цэдэнбал", Д.Төрбат "Маршалын нууц товчоон" номуудын нээлт болсон бол Соёлын төв өргөөнд Ю.Цэдэнбал агсаны 100 жилийн ойд зориулсан Баярын хурал, хүндэтгэлийн концерт болсон юм. УБТЗ-ын хамт олонд УИХ-ын гишүүн, ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат талархал илэрхийлээд "Монгол Улсын иргэдийн 13-хан хувь бичиг үсэг мэддэг байсныг энэ хүний гавъяагаар 100 хувьд хүргэж НҮБ-д бүртгүүлэн шагнуулж байлаа. Атар газрыг эзэмшиж, сангийн аж ахуйнуудыг байгуулан, нэгдэлжих хөдөлгөөнийг бий болгон соёлын довтолгооныг үүсгэж байлаа. Хүн амаа эрүүлжүүлсэн, боловсруулсан, соён гэгээрүүлсэн, 44 жил төр барих хугацаандаа 220 мянган Монгол залуучууд гадаадад боловсрол эзэмшиж, орчин цагийн сэхээтний үндсэн мэргэжилтнүүдийг бий болгосон гээд яриад байвал Ю.Цэдэнбалын Монголын төлөө, түүхэнд оруулсан гавъяаг тоолж барашгүй юм" гэлээ. Дашрамд дурьдахад, Ю.Цэдэнбал агсны албан хэрэгцээнд зориулсан тус вагоныг Бүгд найрамдах Унгар улсад үйлдвэрлэж, 1961-1971 онуудад ашиглаж байжээ.

> ...Хүн амаа эрүүлжүүлсэн, боловсруулсан, соён гэгээрүүлсэн, 44 жил төр барих хугацаандаа 220 мянган Монгол залуучууд гадаадад боловсрол эзэмшиж, орчин цагийн сэхээтний үндсэн мэргэжилтнүүдийг бий болгосон гээд яриад байвал Ю.Цэдэнбалын Монголын төлөө,...





Мөн УБТЗ-ын дарга асан Раднаабазарын Раш албан хэрэгцээндээ, 2004-2006 онд УБТЗ-ын нэгдүгээр орлогч дарга Л.Пүрэвбаатар, мөн гадны өндөр хэмжээний зочид төлөөлөгчдийн тусгай хэрэгцээнд энэхүү вагоныг ашиглаж байгаад 2015 оноос түүхэн дурсгалаар хадгалж, "Зочны өргөө"-ний зориулалтаар ашиглах болжээ.





# ДЭЛХИЙ

МM тойм: ДЭЛХИЙ

# СОЛОНГОСЫН ХОЙГИЙН БАЙДАЛ ХУРЦАДСАН ДОЛОО ХОНОГ

Б.ДАВАА

*Өнгөрсөн долоо хоногт дэлхий дахинаа болсон онцлох үйл явдлыг тоймлон хүргэж байна.*







## Солонгосын хойгийн байдал хурцадлаа

БНАСАУ тав дахь цөмийн зэвсгээ туршсантай холбогдуулан БНСУ онц байдал зарлаж, дайны бэлэн байдалд шилжсэнээ мэдэгдсэн нь өнгөрөгч долоо хоногийн хамгийн их дуулиан тарьсан үйл явдал байлаа. Тодруулбал, Пхеньян дахин цөмийн зэвсэг туршихаар бэлтгэж буйг АНУ, БНСУ-ын тагнуулынхан олж мэдсэнээр солонгосын хойгийн байдал түгшүүртэй болж эхэлсэн юм. БНСУ-ын Батлан хамгаалах яамнаас хэвлэлийн хурал зарлаж, солонгосын хойгийн байдал урьд өмнө нь байгаагүй хамгийн муу төвшинд хүрснийг онцолжээ. Улмаар үүнтэй холбогдуулан Өмнөд Солонгосын цэргийнхэн Пхеньяны цөмийн зэвсэг ашиглан түрэмгийлж болзошгүй аюулаас сэрэмжлэн бүх бэлтгэлийг хангаж дайны бэлэн байдалд шилжиж, ажиглалтаа чангатгажээ. Энэ түгшүүртэй нөхцөл байдалд АНУ БНСУ-д дэмжлэг үзүүлэхээ илэрхийлж, АНУ-ын стратегийн бөмбөгдөгч хоёр онгоц Гуам дахь АНУ-ын цэргийн баазаас Сөүлд газардсан юм. АНУ-ын талаас энэ нь Хойд Солонгост “ноцтой үр дагавар дагуулна” хэмээн анхааруулсан байна. Тус улсын БНСУ-д нийлүүлсэн “B-1” бөмбөгдөгчид нь цөмийн пуужин болон бөмбөгүүдийг тээх чадалтай аж. Түүнчлэн, БНСУ-ын зарим эх сурвалж Хойд Солонгос улсаас цөмийн халдлага явуулах ямар нэгэн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд тус улсын нийслэл Пхеньян хотыг бөмбөгдөн газрын хөрснөөс арчин хаях төлөвлөгөөг Өмнөд Солонгос хэдийнэ боловсруулсан гэж дамжуулсан. Мөн Хойд Солонгосын хилийн зурвасуудад танкийн цуваа байрлуулснаас гадна Япон, АНУ-ын цэргийн зөвлөл далайн флотын хүчээ бэлэн байдалд оруулсан гэх мэдээлэл ч байгаа юм.

...АНУ-д өнгөрөгч амралтын өдрүүдэд хэдхэн цагийн зайтай хоёр удаагийн дэлбэрэлт боллоо. Эхнийх нь Нью Жерси мужид болсон бүх нийтийн таван км-ын гүйлтийн үеэр болсон бол дараагийнх нь Нью Йоркийн Манхаттанд болсон байна. Тодруулбал, Нью Жерси мужид тэнгисийн цэргийнхний зохион байгуулсан хандивын бүх нийтийн таван км-ын гүйлтийн үеэр хогийн саванд хаясан тэсрэх бөмбөг бүхий гаанс дэлбэрчээ..

## Өмнөд Солонгост 5.8 магнитудын хүчтэй газар хөдлөв

Өмнөд Солонгосын цаг уурын хүрээлэнгээс тус улсын өмнөд этгээдэд 5.8 магнитудын хүчтэй газар хөдөлсөн тухай мэдээлсэн. Өмнөд Солонгос улсад өмнө нь ийм хэмжээний хүчтэй газар хөдөлж байсан удаагүй аж. Газар хөдлөлтийн голомт Кёнжу хотын ойролцоо байрлаж байсан бөгөөд нутгийн өмнөд хэсэгт эхэндээ 4.9, 5.4 магнитудын хүчтэй газар хөдлөлт дараалан ажиглагдсаны дараа 5.8 магнитудын хүчтэй газар хөдлөлт болсон байна. Азаар хүний амь эрсдээгүй юм. Гэхдээ найман хүн гэмтсэн гэдгийг эх сурвалж өгч байна. Солонгосын хойгт өмнө нь 5.3 магнитудын хүчтэй чичиргээн мэдрэгдэж байсан удаатай. Гэхдээ АНУ-ын Геологийн судалгааны хүрээлэн Хойд Солонгос цөмийн зэвсэг туршсантай холбоотойгоор чичиргээн үүссэнийг онцолсон байдаг. Энэ удаагийн газар хөдлөлт 1978 оноос хойшхи хамгийн хүчтэй газар хөдлөлтөд тооцогдож байна. Байгалийн гамшигт үзэгдлийн улмаас эвдэрч хэмхэрсэн тавилгандаа дарагдаж гэмтсэн, байшин барилгад ан цав гарсан, усны хоолой хагарсан гэх мэт дуудлага 250 гаруй удаа бүртгэгджээ. Түүнчлэн цаашдаа зургаагаас дээш магнитудын хүчтэй газар хөдөлж магадгүйг холбогдох байгууллагаас анхааруулсан байдаг.



## Дэвид Камерон улс төрөөс гарчээ

Их Британийн Ерөнхий сайд асан Дэвид Камерон конгрессийн гишүүний албан тушаалаасаа огцорч, улс төрийн ертөнцөөс гарч буйгаа мэдэгдсэн. Тэрбээр энэ шийдвэрээ тайлбарлахдаа Их Британийн шинэ Засгийн газрын үйл ажиллагаанд саад учруулахыг хүсэхгүй байна гэж мэдэгдсэн байна. Мөн парламентын нийтийн танхимын гишүүний хувиар эсэргүүцэж байсан боловсролын системийн шинэтгэлийг сайд нар танхим хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаатай энэ шийдвэр нь холбоогүй гэдгийг онцлон тэмдэглэжээ. Ерөнхий сайд асан тэрбээр хэдийгээр конгрессын гишүүнийхээ бүрэн эрхээс татгалзаж байгаа ч, олон нийтийн төлөө хүчин зүтгэж, олон улсын асуудлаарх байр сууриа илэрхийлж байх болно гэдгээ ч дурьдсан байна. Их Британид Европын холбооноос гарах эсэх талаарх бүх нийтийн санал асуулга болж, иргэдийн ихэнхи нь гарах сонголтыг хийсний дараа ард иргэдээ үлдэх сонголт хийхийг уриалж байсан экс Ерөнхий сайдын хүчин чармайлт талаар болсон. Тэгвэл тэрхүү явдлаас хойш гурван сар хүрэхгүй хугацааны дараа Дэвид Камерон улс төрийн ертөнцөөс “тэтгэвэртээ гарч” байгаагаа мэдэгдсэн юм. Эдүгээ 49 настай экс Ерөнхий сайд зургадугаар сард болсон санал асуулгын дараа албан тушаалаасаа огцрохоо мэдэгдэж байв. Харин долдугаар сард Тереса Мэйд Ерөнхий сайдлын суудлаа шилжүүлэн өгсөн байдаг. Дэвид Кэмерон 2001 оноос хойш Оксфордшир мужийн Уитни тойргоос парламентад сонгогдож байсан юм. Түүний парламентын нийтийн танхимын гишүүний бүрэн эрх 2020 онд дуусах ёстой байсан билээ.

## Индонез бүсгүй Филиппинд цаазлууллаа

Индонез, Филиппин хоёр улс цаазын ялыг эдүгээ хүртэл халаагүй улс гэдгээрээ олон улсын анхаарлыг ихээр татдаг. Тэгвэл өнгөрөгч долоо хоногт хар тамхичдын эсрэг хатуу бодлого баримталж буй Филиппиний Ерөнхийлөгч Дютерт тус улсад хар тамхины хэргээр баривчлагдан хоригдож байсан индонез бүсгүйн цаазын ялыг гүйцэлдүүллээ. Индонезийн иргэн Мэри Жэйн 2009 онд 2.6 килограмм хар тамхийг биедээ авч яваад баривчлагдан, цаазын ял сонсч байжээ. Түүнийг эх оронд нь шилжүүлэх талаар төр засгийн хэмжээнд анхаарал хандуулан ажиллаж, нийгмийн байгууллагуудын зүгээс цаазын ялыг цуцлахыг хэд хэдэн удаа шаардаж байсан аж. Индонезийн Жакарта хотноо болсон төрийн тэргүүнүүдийн дээд хэмжээний уулзалтын үеэр Дютерт тус улсын Ерөнхийлөгчөөс цаазын ялыг гүйцэлдүүлэх зөвшөөрөл хүссэн гэнэ. Улмаар цаазыг гүйцэтгэх хугацааг хойшлуулахад талууд санал нэгдээд байжээ. Гэвч хоёр нялх хүүхэдтэй, хар тамхины хэрэгтэн бүсгүй нас барсныг тохиролцоонд хүрснээс ердөө хоёр хоногийн дараа улсын Ерөнхийлөгчид нь хүргэсэн байна. Өнгөрсөн жил ч гэсэн хоёр улсын төр засгийн тэргүүнүүдийн хооронд Мэри бүсгүйн цаазын ялыг хугацааг сунгах талаарх хэлэлцээр болж, түр хугацаагаар сунгаад байжээ. Гэхдээ Филиппиний тал Ерөнхийлөгч Дютерт Индонезийн хуулийг хүндэтгэсэн төдий гэх тайлбараар Мэри Жэйн бүсгүйн цаазын ялыг гүйцэтгэснээ зөвтгөсөн байна.

## АНУ-д хоёр удаагийн дэлбэрэлт боллоо

АНУ-д өнгөрөгч амралтын өдрүүдэд хэдхэн цагийн зайтай хоёр удаагийн дэлбэрэлт боллоо. Эхнийх нь Нью Жерси мужид болсон бүх нийтийн таван км-ын гүйлтийн үеэр болсон бол дараагийнх нь Нью Йоркийн Манхаттанд болсон байна. Тодруулбал, Нью Жерси мужид тэнгисийн цэргийнхний зохион байгуулсан хандивын бүх нийтийн таван км-ын гүйлтийн үеэр хогийн саванд хаясан тэсрэх бөмбөг бүхий гаанс дэлбэрчээ. Азаар хүн гэмтэж бэртээгүй хэдий ч, гүйлтийн үйл ажиллагаа тасалдахад хүрсэн байна. Дэлбэрэлт гүйлтэд оролцож буй хүмүүс хогийн савны ойролцоо ирэх цагт болохоор төлөвлөгдсөн байсан ч, азаар гүйлт цагаасаа хоцорч эхэлсэн тул хүний амь эрсдээгүй байна. Гүйлтэд 3000 орчим хүн оролцжээ. Харин үүнээс хэдхэн цагийн дараа Нью Йорк хотын Манхаттанд дэлбэрэлт болж, 29 хүн гэмтсэн байна. Хохирогчдын нэгийнх нь биеийн байдал түйлын хүнд байгаа аж. Нью Йорк хотын захирагч Билл де Бласио дэлбэрэлтийн талаар мэдээлэхдээ зохион байгуулалттай ажиллагаа гэж үзэж буйгаа мэдэгдсэн байна. Дэлбэрэлт орон нутгийн цагаар 20.00 цагийн үед болжээ. Одоогоор дэлбэрэлтийн шалтгаан тодорхойгүй байгаа ч, хэвлэлийнхэн хогийн сав дэлбэрсэн гэдгийг онцолж байгаа юм. Тиймээс дээрх хоёр удаагийн дэлбэрэлт хоорондоо холбоотой байх магадлалтай гэдгийг зарим эх сурвалж онцолж байна.

ХААН БАНК

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Сонгон шалгаруулалт зарласан огноо: 2016.09.14

ДОХИОЛОЛ ХАМГААЛАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЖ, СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАН ХАМТРАН АЖИЛЛАХ КОМПАНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

ХААН Банкны орон нутгийн салбар нэгжид ашиглагдах дохиоллын тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлж, суурилуулах, дохиоллын системийн үйл ажиллагааг 24 цагийн турш хянах мэдээ дамжуулах гэрээт компанийг сонгон шалгаруулах тул энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг туршлагатай байгууллага, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй байгууллагууд ХААН Банкны 5000004506000035 тоот дансанд 50,000 төгрөгийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэй тушааж, баримтыг оролцох хүсэлтийн албан бичгийн хамт Төв ХААН Банкны ресепшинд өгч, сонгон шалгаруулалтын өгөгдлийг авна уу.

Материалыг 2016 оны 09 дугаар сарын 28-ны өдрийн 12:00 цаг хүртэл Төв ХААН Банкны ресепшин хүлээн авах ба зөвхөн шалгарсан компани, аж ахуйн нэгжид бичгээр хариу мэдэгдэнэ.

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Сөүлийн гудамж-25, ш/х-192 Улаанбаатар 14250

Сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг procurement2016@khanbank.com хаягт хандаж авна уу.

Харилцагчийн мэдээллийн төв 1800-1917 www.khanbank.com khanbank.com/facebook khanbank.com/twitter

“УЛААНБААТАР ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫГ ТАТАН БУУЛГАСАН ТУХАЙ

1. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 501 дүгээр тогтоолоор “Улаанбаатар төлөөлөгчийн газар” УТҮГ-ыг татан буулгасан болно.

2. “Улаанбаатар төлөөлөгчийн газар” УТҮГ-ыг татан буулгасантай холбоотойгоор нэхэмжлэгчдийн өргөдлийг 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 17 цаг 30 минут хүртэл 2 сарын хугацаанд Энхтайваны өргөн чөлөө “UBH” төвийн 8 дугаар давхарт хүлээн авна.

Холбоо барих утас: 70006622, 99105491

ТАТАН БУУЛГАХ КОМИСС

# ШУУРХАЙ МЭДЭЭ

## “ХҮҮХДИЙН ТУСЛАМЖИЙН УТАС-108” ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ БОЛЛОО

Ж.ОТГОН

*Сүүлийн жилүүдэд хүчирхийллийн улмаас хүүхдүүд хазуулж, зодуулсан, тэр бүү хэл амь насаараа хохирсон олон тохиолдол ил болсноор нийгмийн анхаарал “Хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэрэг”-т чиглээд буй. Энэ хүрээнд хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, яаралтай хамгааллын үйлчилгээ үзүүлэх зорилгоор “Хүүхдийн тусламжийн утас-108”-ын ажиллуулж буй. Энэхүү талаар “Хүүхдийн тусламжийн утас-108”-ын зохицуулагч М.Энхболдоос тодрууллаа.*

**-Хүүхдийн тусламжийн утас нэлээд эртнээс үйл ажиллагаа явуулж эхэлсэн гэдэг. Яг хэзээнээс хүүхдүүдийн дуу хоолойг сонсч, тэндэд туслаж эхэлсэн юм бэ?**

-Яаралтайхамгааллынүйлчилгээүзүүлэхэдчиглэсэн“Хүүхдийн тусламжийн утас-108” нь хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой. Хамгааллын үйлчилгээ шаардлагатай дуудлагад бэлэн байх “Хүүхэд хамгааллын яаралтай тусламжийн алба” гэж хэлж ойлгож болно. Энэхүү утас маань өнгөрсөн наймдугаар сарын 24-ны өдөр Засгийн газрын тогтоолоор төрийн үйлчилгээний албанд албан ёсоор баталгаажиж байна. Хүмүүс энэ ажил саяхан гэнэт эхэлчихсэн юм шиг буруу ойлгоод байдаг. Гэтэл энэхүү ажил 1998 оноос үүдэлтэй маш олон хүний хүч хөдөлмөрийн үр дүнд бий болсон. Өөрөөр хэлбэл, гэнэт шинээр санаачлаад хийчихсэн ажил биш. Өмнө нь 1998 онд “Өсвөрийн үеийн ирээдүй төв”, “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” анх удаа хүүхдийн тусламжийн буюу Итгэлийн утас, Сэтгэлийн утас гэсэн гэсэн хоёр дугаар ажиллуулж байлаа. Харин 2001 онд тус утсыг Засгийн газар өөр дээрээ аваад, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө хороо гэдэг хүүхдийн байгууллага болгосон. Уг байгууллага 1615 утсыг ажиллуулж, хүүхдүүдийнхээ дуу хоолойг нь сонсч, хамгаалах шаардлагатай хүүхдүүддээ үйлчилгээ үзүүлж эхэлсэн. Харин 2004 оноос энэ нь өөрчлөгдөөд “Найз утас 1979” болсон. Үүнээс хойш 2014 онд хүртэл “Найз утас 1979” нэрээр ажиллаж байгаад, төрийн яаралтай тусламж үйлчилгээний гурван оронтой дугаарыг аваад үнэ төлбөргүй, 24 цагаар, амралтгүй долоо хоногийн турш ажиллаж эхэлсэн.

**-“Хүүхдийн тусламжийн утас-108” нь төрийн үйлчилгээний алба болж байгаа гэсэн. Энэ талаар тодруулаач?**

-Эрх зүйн үндэс нь болохоор 2010 онд Засгийн газраас батлагдсан “Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх төлөвлөгөө” гээд дунд хугацааны стратеги төлөвлөгөөний 6.3-т заасан байдаг. Энэхүү төлөвлөгөөнд 2014 онд хүүхдийн тусламжийн утсыг гурван оронтой үнэ төлбөргүй болгоно гэсэн байгаа. Тиймээс энэхүү төлөвлөгөөнийхөө дагуу л явж байсан. Харин 2014 онд эдийн засгийн, улс төрийн гээд олон асуудлаас болоод, төсөл хэлбэрээр хэрэгжүүлж эхэлсэн. Хүүхдийн төлөө үндэсний газар “Дэлхийн Зөн-Монгол” олон улсын байгууллага болон Мобиком компантай хамтран гурван талын хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зураад, гурван жилийн хугацаатай буюу 2017 оны зургадугаар сарын 01-ны өдрийг хүртэл төсөл хэлбэрээр хэрэгжүүлэхээр болсон байдаг. Гэтэл энэхүү төслийн хугацаа дуусахын өмнө шинэ Засгийн газар гарч ирээд “Хүүхдийн тусламжийн утас бол яг хүүхэд хамгаалалд маш хэрэгтэй зүйл байна” гэж үзсэн. Тиймээс ч санал оруулж, Засгийн газрын хуралдаанаар батлагдаад байна. Өнөөдөр“Хүүхдийн тусламжийн утас-108” албан ёсоор төрийн үйлчилгээний төв болон үйл ажиллагаа эхлүүлээд байна.

**-Энэхүү үйлчилгээний төвд хүүхдүүд хандсанаар ямар тусламж үйлчилгээг авах боломж нээгдэж байгаа вэ?**

-Манайд хүүхэд хамгааллын яаралтай тусламжийн үйлчилгээ гэж байгаа. Түүнчлэн хүүхдийн эрхийн зөрчлийн тухай мэдээллүүдийг хүлээн авч байна. Улмаар энэ хүрээнд хүүхдэд энэ талын хэрэгтэй мэдээллүүдээр хангаж байгаа. Мөн ямар нэгэн асуудалтай байгаа хүүхдүүддээ сэтгэл зүйн зөвлөгөө өгнө. Мэдээж сэтгэл зүйн зөвлөгөө өгч байгаа гэхээр мэргэжлийн хүн мөн үү гэдгийг хүмүүс лавладаг. Ер нь бол Монголд хүүхдийн утсны зөвлөх сэтгэл зүйч гэх мэргэжил байхгүй. Харин бид 2014 оноос хойш сэтгэл зүйчдээ сургалтад хамруулаад, мэргэшүүлээд, чадваржуулаад л явж байгаа.

**-“Хүүхдийн тусламжийн утас-108”-д хэр олон хүүхэд ханддаг юм бэ?**

-Хүүхдийн хандалтын хувьд сүүлийн хоёр жил гурван сарын хугацаанд 490 гаруй мянган хандалттай байгаа. Үүнээс 340 гаруй мянга нь яг бүртгэгдсэн, бусад нь техникийн буюу шугам давахцах зэрэг шалтгаанаас болоод бүртгэгдээгүй байгаа юм. Бүртгэгдсэн дуудлага дотроос 36.3 хувь нь яг зорилтод дуудлага байсан. Өөрөөр хэлбэл, хамгааллын үйлчилгээ шаардлагатай дуудлага байсан гэсэн үг. Үлдсэн нь нэн яаралтай үзүүлэх буюу хүүхдийг аюултай эрсдэл нөхцөл байдлаас таслан зогсоох 1.7, мэдээдэл өгсөн 16.3, зөвлөгөө өгөх 9.2 хувийн дуудлагууд бүртгэгдсэн.

**-Хүүхдүүдэд нэн яаралтай тусламж шаардлагатай газарт очиж, тусламж үзүүлэх зэрэгт төвийн ажилчид хүрч ажиллаж чадаж байгаа юу?**

-Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоо нь 21 аймаг, есөн дүүрэгтээ хуваагдчихсан байдаг. Тэнд нь Хүүхэд гэр бүл хөгжлийн байгууллагууд, хамгааллын мэргэжилтнүүд ажиллаж байна. Тиймээс бид үндэсний хэмжээнд 30 төрийн нэгжид шууд хүүхэд хамгааллын асуудлаар холбогдоод, хүүхдүүддээ шаардлагатай үйлчилгээг үзүүлж байгаа. Мөн холбогдох төрийн байгууллагууд буюу МХЕГ, Нийтийн тээврийн удирдах газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар гээд маш олон байгууллагууд руу холбогдоод эндээсээ зохицуулалтаа хийгээд явчихдаг.

**-Энэхүү тусламжийн утасны талаар иргэд хэр мэдээлэлтэй байдаг бол. Хамгийн их лавлаж асуудаг асуулт юу байна?**

-Манай утас бүрэн хүчин чадлаараа ажиллаад, хоёр жил болж байна. Олон улсын туршлагаар 5-10 жилийн дараа энэхүү утас нийгэмд танигддаг гэж ярьдаг юм билээ. Тиймээс ч “Энэ ямар учиртай утас вэ, ямар асуудлаар хандаж болох уу” гэх асуулт зонхилдог. Харин зөвлөгөөний хувьд хандаж байгаа хүүхдүүд үеийн найзуудын харилцааны асуудлаар маш их зөвлөгөө авдаг. Үүний дараа гэр бүлийн харилцааны асуудал ордог. Үүнээс нэг дүгнэлт хийж болно. Тодруулбал, хүүхэд өөрт тулгамдаж байгаа асуудал бүртээгээ өөрөө нүүр тулдаг болсон гэсэн үг. Учир нь эцэг, эх, гэр бүл нь цаг зав муутай учир хүүхдэд үзүүлэх сэтгэл зүйн дэмжлэг багассан. Хүүхдийнхээ суурь эрхийг нь буюу хоол хүнс, өмсч зүүхээр хангаж чадаж байгаа ч сэтгэл зүйн хувьд дэмжлэг болж чадахгүй байна гэдгийг манайд ирж байгаа дуудлагуудаас бэлэхнээ харж болно. Харин хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийллийн ихэнхийг бие мах бодийн хүчирхийлэл буюу зодуур эзэлж байна. Энэ нь ганцхан удаагийн зохих, зодох асуудал биш. Байнгын зодуурт өртөж байгаа нь маш их санаа зовоож байна. Энэ хүрээнд мэргэжлийн байгууллагуудын хамгийн их санаа зовоож байгаа нэг асуудал нь бэлгийн хүчирхийллийн асуудал болоод байна. Бид нэн тэргүүнд хүүхдийн бие мах бодь, сэтгэцийн эрүүл мэндэд нөхөж барашгүй хохирол учруулж болзошгүй үйлдэл бүрийн онцолж үздэг. “Хүүхдийн тусламжийн утас-108”-д мэргэжлийн хүмүүс нь энэ дуудлагыг “Халуун дуудлага” гэж ярьдаг. Тиймээс ч энэ асуудал дээр ЦЕГ-ын дэргэдэх мэдээлэл шуурхай удирдлагын төвтэй нягт хамтарч ажилладаг. Харин ЦЕГ-тай хамтран ажиллах санам бичигт 108 утсанд ирсэн “Халуун дуудлагад” цагдаагийн алба хаагчидхамгийнтүрүүндүйлчилнэ гэж заасан байгаа. Үүнийг маш том ахиц гэж харж харж байгаа. Мөн 101, 103, 105 гээд онцгой албадууд хүүхдийн тусламжийн 108 утаснаас ирсэн дуудлагуудад маш хурдан, шуурхай үйлчилдэг. Түүнчлэн 21 аймаг, есөн дүүрэг, бүх сум, хороод дээр ажиллаж байгаа “Хүүхэд хамгааллын хамтарсан баг” буюу Засаг даргаар нь удирдуулсан нийгмийн ажилчид ч манай дуудлагад маш сайн ажиллаж байгаа. Дашрамд дуулгахад, 2015 оны гуравдугаар сараас эхлээд хөндлөнгийн дуудлага ихэсч байгаа. Тухайлбал, “Энэ айл хүүхдээ зодоод байх шиг байна. Хүүхэд нь байнга уйлах юм” гэх зэргээр дуудлага мэдээлэл өгдөг болоод байгаа.

## Хар тамхи борлуулдаг бүлэг этгээдүүдийг баривчлав

Эрүүгийн цагдаагийн газрын Хар тамхитай тэмцэх хэлтсийн алба хаагчид энэ сарын 15-16-нд шилжих шөнийн 04:00 цагийн орчимд нийслэлийн Сүхбаатар , Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрээс хар тамхи хууль бусаар зарж борлуулдаг, хэрэглэдэг бүлэг этгээдүүдийг баривчилсан байна. Баттай эх сурвалжийн мэдээлж буйгаар, баривчлах ажиллагааны үеэр сэжигтнүүд автомашинтайгаа зугтахыг оролдож, улмаар цагдаагийн алба хаагчийн биед халдаж албаны автомашин мөргөсөн байна. Тиймээс Хар тамхитай тэмцэх хэлстийн алба хаагчид баривчилгааны үеэр галт зэвсэг хэрэглэн саатуулжээ. Сэжигтнүүд нь Улаанбаатар хотын харьяа 18-35 насны нийт долоон хүн байсан бөгөөд хэргийн газраас эд мөрийн баримтаар, айс буюу мөс, каннабисийн ургамалын төрөл буюу боловсруулсан шавар, мансуурууулах сэтгэцэд нөлөөлөх экстази болон эдгээрийг хэрэглэх гуурс, мөнгөн цаас зэрэг хэрэгслүүд хураан авсан байна. Баригдсан этгээдүүдийн гурав нь өмнө нь хар тамхины хэрэгт холбогдон шалгагдаж, хавтаст хэрэг нь прокурорын газарт хянагдаж байх үед давтан гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдоод байгаа аж. Тиймээс гурван иргэнийг ШШГЕГ-ын харьяа цагдан хорих 461-р ангид хорьсон байна. Эдгээр этгээдүүдийг хар тамхи хууль бусаар худалдан борлуулж хэрэглэсэн, давтан үйлдлээр гэх үндэслэлээр Монгол улсын Эрүүгийн хуулийн 192.2, 230.1 зааснаар хэрэг үүсгэн шалгаж байгаа ажээ.

## Хүчингийн хэрэг үйлдсэн лам нарт 3.8 жилийн ял оноожээ

Өвөрхангай аймгийн нутагт байрлах Эрдэнэзуу хийдийн Г, Д, Ж гэх гурван лам өнгөрсөн оны есдүгээр сард архидан согтуурч, улмаар хамт байсан 19 настай эмэгтэйг хүчиндсэн гэх мэдээлэл цагдаагийн байгууллагад иржээ. Тэгвэл уг хэргийн шүүх хурал энэ оны өнгөрөгч зургадугаар сард болж, эрүүгийн хуулийн 126.2.6 буюу бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон гэх зүйл ангиар анхан шатны шүүхээс 3.8 жилийн ял оноож байжээ. Улмаар давж заалдах шатны шүүхээс хэргийг анхан шатны шүүх рүү буцаасан байсан юм. Тэгвэл тус хэргийн шүүх хурал өнгөрсөн долоо хоногт дахин болж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээхээр болжээ. Хүчингийн хэрэг үйлдсэн лам нар нь тус хийдийн голч лам, их гэсгүй лам, тахилч лам нар байсан байна.

## ӨМӨЗО-нд ажиллах бол зөвшөөрөл авахыг анхааруулав

Гадаад харилцааны яамны Консулын газраас урд хөршийг зорих гэж буй иргэдэд зориулан зөвлөмж гаргалаа. Тус зөвлөмжид БНХАУ-ын ӨМӨЗО-ны нутаг дэвсгэрт байрлах жуулчны бааз, ресторанд урлагийн тоглолт хийхээр явахдаа тус улсын хуулийн дагуу зохих зөвшөөрлийг авч, ажиллахыг анхааруулсан байна. Манай иргэд, ялангуяа урлагийн сургуулийн оюутнууд, зуны амралтаар болон бусад үед тоглолт хийхээр гадаад оронд явахдаа гэрээ байгуулан, тоглолт хийх, хөдөлмөр эрхлэх болон оршин суух зөвшөөрлийг авах ёстой. Харин энэ зөвшөөрлийг аваагүйгээс тус улсад хөдөлмөр эрхэлсэн Монголын 26 оюутан цалин хөлсөө авч чадалгүй хохирсон байна. БНХАУ-ын “Гадаадын иргэдийн хилээр орох гарахыг зохицуулах” тухай хуулийн 78 дугаар зүйлд “Гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг хэтрүүлсэн нэг өдөр тутам 500 юанийн мөнгөн торгууль ногдуулах, 5-15 хоногоор саатуулах арга хэмжээ авах”, мөн 80 дугаар зүйлд “Хууль бусаар хөдөлмөр эрхэлсэн гадаадын иргэнийг 5000-20000 юанийн мөнгөн торгууль ногдуулах, ноцтой гэж үзвэл 5-15 хоногоор саатуулна” хэмээн заасан байдаг аж.

PHOTO NEWS



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

*“Сүлдэт багана” цогцолборын нээлт өнгөрсөн баасан гарагт үндэсний цэцэрлэгт хүрээлэнд боллоо. Энэхүү цогцолбор 2017 онд бүрэн ашиглалтад орох бөгөөд одоогийн байдлаар жагсаалын талбайн, хүүхдин тоглоомын талбай, хилчин баатруудын дурсгалын талбай ашиглалтад ороод байгаа ажээ. сонихуулахад тус цогцолборыг хилчид өөрсдийн цалингаас хандив цуглуулан бүтээж байгаа юм байна.*



СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## 22 НАСТАЙ ЗАЛУУ МАШИНТАЙГАА ОНХОЛДОЖ НАС БАРЖЭЭ

Замын цагдаагийн газарт өчигдөр зам тээврийн холбогдолтой 270 дуудлага иржээ. Үүнээс зам тээврийн ослын 213 дуудлага бүртгэгдэж,хоёр хүний амь хохирч, 14 хүн гэмтсэн байна. Тодруулбал, СХД-ийн нутаг Баруун салааны замд T.Prius маркийн машинтай жолооч Н машинтайгаа онхолдож /жолооч 22 настай, эрэгтэй/ газар дээрээ нас баржээ. Түүнтэй хамт явсан зорчигч 22 настай эрэгтэй Л гэмтсэн байна.

No STRESS

# Монголын хамгийн том танхимтай “Corporate cinema” нээлтээ хийлээ



Н.БАТЗАЯА

Одоогоос яг нэг жилийн өмнө Монгол Улсын урлагийн түүхэнд нэгэн шинэ хуудас нээгдэж, олон улсын стандартын шаардлага хангасан концертын танхимыг “The Corporate Hotel & Convention Centre”-ын хамт олон ашиглалтад оруулж байв. Тэгвэл тус хамт олон монголчууддаа дахин нэг гайхалтай “бэлэг” барьж байна. Кино урлаг эрчимтэй хөгжиж, үүнийг дагаад долоо хоног бүр шинэ кино нээлтээ хийх болсон бөгөөд энэ урлагт шимтэгсдийн тоо ч өдөр ирэх тутам өсөн нэмэгдэх болсон юм. Тэгвэл тэдний хэрэгцээ шаардлагад нийцэх өнгө, дүрсний нягтаршил, дууны ялгаралыг төгс мэдрүүлэх том дэлгэц бүхий Монголын хамгийн том танхимтай “Corporate cinema” нээлтээ хийв. Кино театрын нээлтэд кино сонирхогчид болон урлаг соёлын одод оролцсон. Нээлтэд хүрэлцэн ирсэн зочид амтат бялуу, улаан дарс, коктейлаар дайлуулан жазз хөгжмийн аялгуунд бүжиглэн хөгжилдөж, нэгэн үдшийг өнгөрүүлсэн юм.

Нээлтэд ОХУ-ын элчин сайдын зөвлөх Михайлов Евгений Георгиевич оролцож, үг хэлсэн. Тэрбээр “ОХУ-аас Монгол Улсад суугаа элчин сайдын яам, Оросын шинжлэх ухаан соёлын нэрийн өмнөөс болон хувиасаа энэхүү үйл ажиллагааг зохион байгуулж байгаа хамт олонд талархал илэрхийлье. Оросын уран бүтээлчдийн дэлхийн кино урлагт оруулсан хувь нэмрийг нээлтэд хүрэлцэн ирсэн ахмадууд сайн мэдэж байгаа. Тухайлбал, Бондарчукийн “Дайн ба энх”, Владимир Меньшовийн “Амьдрал нулимсанд дургүй”, Никита Михалковийн “Наранд зүдрэгсэд”, “Москва хариу цохилт өглөө” зэрэг Оскарын шагнал хүртсэн олон кино бий. Өнөөдөр та бүгдэд толилуулж байгаа кино бол шинэ үеийн найруулагчдын бүтээл. Энэ бүтээлд оросын кино урлагийн бүх сайхан чанарыг шингээсэн” гэв. Корпорейт кино театрт 4K нягтралтай сүүлийн үеийн CHRISTIE брендийн проекторт, Dolby 7.1 суурилуулсан аж. Харин дэлгэцийн хэмжээ нь 14.4*6.025м хэмжээтэй бөгөөд 1200 хүний суудал бүхий танхимтай юм байна. Нээлтийн үеэр тус кино театрын “The Corporate Hotel & Convention Centre” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Отгондулам “Манай Corporate Hotel and Convention Centre концертын зааландаа томоохон хэмжээний урлаг, соёлын олон үйл ажиллагааг зохион байгуулж байсан. Харин энэ удаад уг зааланд кино театрын үйл ажиллагаа явуулж байна. Өнөөдөр кино театрын нээлт боллоо. Бид кино театрынхаа нээлтийг орос улсын “Нислэгийн баг-Амь өрссөн даалгавар” киногоор эхэллээ. Яагаад заавал орос киногоор нээлтээ хийж байгаа юм бэ гэж зарим хүмүүс гайхаж магадгүй. Учир нь гэвэл бүх л кино театрууд холливудын киногоор нээлтээ хийдэг. Мөн энэ жил Монгол, Орос улсын хооронд дипломат харилцаа үүссэний 95 жилийн ой тохиож байгаа. Тиймээс орос киногоор театрынхаа нээлтийг хийж байна.

Манай кино театр бусад театруудыг бодвол онцлогтой. Нэгдүгээрт, заалны хүчин чадлын хувьд хамгийн том нь учраас киноны нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад илүү тохиромжтой. Одоогийн байдлаар хоёр монгол киноны нээлт хийх санал ирсэн байгаа. Хоёрдугаарт, дуу дүрс, техник, технологийн хувьд маш сайн. Цаашид “Corporate cinema” тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж, үзэгчиддээ маш олон гэнэтийн бэлэг барих болно” гэв. Харин кино сонирхогчид тус кино театрын талаар сэтгэл ханамжтай байгаа нь киноны дараа харагдаж байв. Тэд “Их сайхан кино театр нээлтээ хийжээ. Бүх зүйл нь дээд зэргийн санагдлаа. Өнгө дүрсний ялгарал маш гайхалтай. Их тод харагдаж байна билээ. Мөн дууны хувьд ч гэсэн яг л тухайн орчинд очсон мэт сэтгэгдэл төрүүлсэн” хэмээсэн. Ямартай ч Монголын кино театрт хувьсгал хийж, орчин үеийн стандартад нийцсэн, дээд зэрэглэлийн нэгэн кино театр ийнхүү нээгдлээ.



Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 21
Шөнө 6

Нөгөөдөр
Өдөр 19
Шөнө 7

## Өдрийн зурхай

**Намрын дунд улаагчин тахиа сарын Зургаан цагаан мэнгэтэй Хөх луу өдөр. Сумъяа гараг**

**Үс засуулбал:** Эд, малын гарлагатай
**Наран ургах, шингэх:** 06:36 - 18:56



*Өдрийн өнгө: Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба угаал үйлдэх, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, дарханы үйлд сайн. Гүүр тавих, газар шороо ухахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахайболой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.*


ТЭНГИС SINCE 1981 КИНО ТЕАТР




**90-ээд оны үед залуусын дунд нэрд гарч байсан хамтлаг тодорхой шалтгааны улмаас тарцгааж киноны үйл явдал эхэлнэ. Залуус тус тусын амьдралыг хөөж 20 жил өнгөрсний дараа хамтлагийн нэг гишүүн эргэн нэгдэх санал тавьж үйл явдал өрнөх болно. Урлаг тэднийг хүлээн авах болов уу?**




**Артур Бишоп урьд хийдэг байсан ажлаа орхиж тайван амьдрахыг хүссэн боловч түүний дайснууд хайртай бүсгүйг нь олзолно. Яах ч аргагүй байдалд орсон тэрээр дэлхийн талыг туулж 3 том аллага үйлдэх хэрэгтэй болдог. Гэвч энэ бүх ажиллагаа санаандгүй болсон мэт харагдах ёстой.**





## Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

Т.Амбиа

Сая Icetop хамтлагийн дууг сонсож байлаа. Гэтэл эмээ хажууд харж харж байснаа “Хөөрхий дөө ийм сайхан залуучууд ингээд хараагүй болчих гэж” гэнээ. Хаха

ДУУЛГАХ СОНИН

## Нийслэлчүүд “НОМЫН БАЯР”-аа тэмдэглэлээ

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж 2012 онд 158 дугаар зарлиг гаргаж жил бүрийн есдүгээр сарын гурав дахь долоо хоногийн бямба гарагийг “Номын баярын өдөр” болгосон билээ. Тэгвэл уламжлал ёсоор тав дахь удаагийн Номын баяр Сүхбаатарын талбайд болов. Энэ удаагийн номын баярт зохиогч, орчуулагч болон хэвлэлийн 126 орчим аж ахуй нэгж оролцсон бөгөөд ЕБС-ийн сурах бичгүүд, сонгомол зохиол, хүүхэд залуусын нэвтэрхий толь болон гадаад хэлний толь бичиг борлуулж буй асарт хүүхэд, залуус олноор цугласан байлаа. Номын баярын үеэр хэвлэлийн байгууллагууд номоо 20-50 хувийн хямдралтай худалдаалж байсныг номонд шимтэгсэд олзуурхан хүлээн авч байсан юм. Тухайлбал, Мир номын дэлгүүрийнхэн "Үлгэрийн орноор аялая, Хүүхдийн сонгодог зохиолууд, Амьд мэт Бяцхан театрууд, Буддаг ном, 3D цуврал, Хэлд оруулж үг заадаг ном, Буратино, Алиса, Дэлхийн атлас, Анна франкийн түүх зэрэг бусад бүх хит номуудаа 20 хувь хямдруулан худалдаалж байна. Сюзан Коллинсын “Өлсгөлөн тулаан” номыг 17 мянган төгрөгөөр худалдаалдаг бол энэ өдөр 13 мянган төгрөг болгон хямдруулжээ. Түүнчлэн “Али Баба ба дөчин дээрэмчин”, “Аладдины шидэт дэнлүү” зэрэг хүүхдийн ном 22 мянгаас 30 хувь хямдран 15 мянга 400 төгрөгөөр, “Алиса гайхамшгийн оронд” ном 35 мянгаас 30 хувь хямдарч 24500 төгрөгөөр борлуулж байна. Мөн хүүхэд багачуудын унших дуртай "Бумбардай" комик ном 12500 төгрөг болон хямдарсан байв.



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

## Жүжигчин Ж.Оюундарь ШИЛДЭГ ЭМЭГТЭЙ ТУСЛАХ ДҮРИЙН ШАГНАЛ ГАРДЛАА

Буриадын Улаан-Үд хотноо энэ сарын 11-16-нд “Алтан сэргэ” олон улсын театрын наадам болжээ. Энэхүү наадамд УДЭТ-н уран бүтээлчид “Ромео Жульетта” жүжгээр амжилттай оролцсон байна. Улмаар "Ромео Жульетта" жүжгийн өрлөг эхийн дүрээр Ж.Оюундарь Шилдэг эмэгтэй туслах дүрийн шагнал хүртэн “Алтан сэргэ”-ийг гардан авчээ. Түүнээс гадна "Алтан Сэргэ" наадмын шүүгчдийн нэрэмжит тусгай байрын шагналын эзнээр "Ромео Жульетта" жүжгийн Ромеод тоглосон УДЭТ-н жүжигчин Б.Шинэбаяр тодорсон байна.

